1.9.	Ил тод, хариуцлагатай олборлох үйлдвэрлэлийг төлөвшүүлж, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах ажлын үр дүнг дээшлүүлэн уул уурхайн үйл ажиллагааны улмаас хүрээлэн байгаа орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх	1	Олборлох үйлдвэрлэлийн ил тод, хариуцлагатай байдал, уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох	2016-2020	УУЯ	СЯ, БОНХАЖЯ	УТ, ОУБ	Уул уурхайн үйл ажиллагаанд хяналт, хариуцлагын тогтолцоо сайжирсан байна, эрх зүйн орчин боловсронгуй болсон байна.
		2	Уул уурхайн үйлдвэрлэлийн сөрөг нөлөөллийг бууруулах хүрээнд дүйцүүлэн хамгааллын загвар, жишиг төслүүдийг хэрэгжүүлж, туршлагыг түгээн дэлгэрүүлэх	2017-2030	БОНХАЖЯ	УУЯ	ОУБ, ХХ	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагааг 5-аас доошгүй төсөлд хэрэгжүүлсэн байна.
		3	Улсын хэмжээнд экосистемийн бүсчлэлийн үнэлгээг нарийвчлан хийж, байгаль, соёлын өвийн хувьд чухал ач холбогдолтой газруудыг тодорхойлж, ашигт малтмалын эрэл хайгуул, олборлолтыг хязгаарлах	2016-2030	БОНХАЖЯ	УУЯ, БСШУЯ	ОУБ	Улсын хэмжээнд байгаль, соёлын өвийн чухал ач холбогдолтой газрууд тодорхой болж, хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.
		4	Цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, олборлолтын үеийн болзошгүй сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, арилгахтай холбогдсон стандарт аргачлал, олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх	2016-2025	ЦЭК	УУЯ, БОНХАЖЯ	ОУБ, УТ, ХХ	Цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, олборлолтод байгаль орчныг хамгаалах олон улсын стандартыг нэвтрүүлсэн байна.
		5	Байгалийн нөөц ашиглах үйлдвэрлэлээс үзүүлэх хуримтлагдах нөлөөлөл, байгаль орчинд учруулсан хохирлын үнэлгээг шаардлагатай бүс нутаг, сав газрын хэмжээнд хийж, хохирлыг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх	2016-2030	БОНХАЖЯ	СЯ, АЗД	ОУБ, УТ, ХХ	15-аас доошгүй бүс нутгийн хэмжээнд хэрэгжүүлсэн байна. Байгаль орчны хохирлыг бууруулах урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн байна.
1.10.	Уламжлалт болон уламжлалт бус газрын тосны эх үүсвэрийн хайгуул, олборлолтод олон улсын стандартыг нутагшуулж мөрдөх, байнгын хяналт-шинжилгээ хийх замаар орчны бохирдлоос сэргийлэх	1	Газрын тосны эх үүсвэрийн хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд олон улсын байгаль орчны шаардлагад нийцсэн стандартыг нэвтрүүлэх	2016-2020	УУЯ	ГТГ, СХЗГ	УТ	Газрын тосны эх үүсвэрийн хайгуул, олборлолтод олон улсын байгаль орчны шаардлагад нийцсэн стандарт нэвтэрсэн байна.
		2	Занар, нүүрсний давхаргын метан хий зэрэг уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үеийн байгаль орчны менежментийн үйл ажиллагааг олон улсын туршлага, стандартад нийцүүлэх	2016-2020	УУЯ	ГТГ, СХЗГ	УТ, ОУБ, ХХ	Олон улсын стандарт, арга, аргачлал нэвтэрч, байнгын хяналт-шинжилгээ хийгддэг болно.
1.11.	Уул уурхайн салбарын орлогоос баялгийн сангийн хуримтлалыг бий болгон урт хугацааны тогтвортой хөгжлийг хангахад зарцуулах	1	Баялгийн сангийн хуримтлалыг бий болгож, байгаль орчныг хамгаалах, нийгмийн сайн сайхан байдлыг бий болгох, эдийн засгийн өсөлтийг хангахад чиглэсэн арга хэмжээнд зарцуулах чиглэлээр эрх зүйн орчныг бүрдүүлэх	2017-2022	СЯ	УУЯ	УТ	Хууль, холбогдох дүрэм, журам батлагдаж, хуримтлал бий болгоно.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга зам	№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт
		2	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж, нөхөн сэргээлгүй орхигдсон газруудыг нөхөн сэргээх санхүүгийн эх үүсвэрийг бий болгож, бүрэн нөхөн сэргээх эрх зүйн орчныг бүрдүүлэх	2017-2030	УУЯ	БОНХАЖЯ	УТ, ХХ, ОУБ	Хууль батлагдан гарч, нөхөн сэргээгдэлгүй орхигдсон газруудыг нөхөн сэргээсэн байна.
1.12.	Байгальд орчинд ээлтэй, хүний эрүүл олон янз байдалд сөрөг нөлөөгүй дэд бүтэц, тээврийн сүлжээг хөгжүүлэх	1	Төмөр зам, авто замын дагуу нүүдлийн зэрлэг амьтдад зориулсан гарц, гарам байгуулах стандарт боловсруулж мөрдүүлэх	2017-2020	БОНХАЖЯ	ЗТЯ, СХЗГ	ОУБ	Стандарт боловсруулсан байна.
		2	Уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн байгаль орчинд сөрөг нөлөө багатай, үр ашигтай байх шийдлийг судлан нэвтрүүлэх	2016-2020	ЗТЯ	УУЯ	ОУБ, ХХ	Тээврийн байгаль орчинд сөрөг нөлөө багатай шийдэл нэвтэрсэн байна.
		3	Гудамж талбай, авто зам, төмөр замын дагуух гэрэлтүүлэгт сэргээгдэх эрчим хүчийг түлхүү ашиглах	2016-2030	АНЗД	ЭХЯ, ЗТЯ	ОНТ, ХХ	Сэргээгдэх эрчим хүчний ашиглалт нэмэгдэж, ая тухтай орчин бүрэлдэнэ.
		4	Авто замын сүлжээг өргөтгөж, хөдөлгөөн зохицуулалтын ухаалаг системийг нэвтрүүлж, автотээврийн хэрэгслээс гарах хорт утааг бууруулах	2016-2025	АНЗД	ЗТЯ	УТ	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, агаарт ялгарах хорт утаа багасна.
		5	Төмөр замын сүлжээг үе шаттайгаар цахилгаанжуулж тээврийн салбараас агаарт ялгаруулах хорт утааг бууруулах	2018-2030	ЗТЯ		УТ	Төмөр замын тээврээс агаарт ялгаруулах хаягдал буурна.
		6	Төмөр замын туннель байгууламж (24 м-ээс гүн ухаж сэтлэх тохиолдолд) барих технологи, тоног төхөөрөмжийг судалж нэвтрүүлэх, стандарт боловсруулж мөрдүүлэх	2016-2020	ЗТЯ	МТЗ	ХХ	Газрын хөрс эвдэгдэхгүй, гүн ухаш үүсэхгүй байх нөхцөл бүрдэнэ.
		7	Агаарын зайн хөдөлгөөн зохицуулалтыг сайжруулах замаар шатахууны хэрэглээг багасгаж, хүлэмжийн хийг бууруулахад чиглэсэн стандарт шаардлагын эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх	2016-2018	ЗТЯ	ИНЕГ	УТ	Агаарын тээвэртэй холбоотой хүлэмжийн хийг бууруулах эрх зүйн орчин, холбогдох стандарт, шаардлага бүрдсэн байна.

## STRATEGIC OBJECTIVE #2

SUSTAIN ECOSYSTEM'S CARRYING  
CAPACITY BY ENHANCING  
ENVIRONMENTAL PROTECTION AND  
RESTORATION ACTIVITIES, AND  
REDUCING ENVIRONMENTAL  
POLLUTION AND DEGRADATION.



№	Зорилтыг хэрэгжүүлэх арга зам	№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт
2.1.	Байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, цэнгэг усны нөөц, гол, мөрний урсац бүрэлдэх эхийн 60-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авч, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 2020 онд нийт нутаг дэвсгэрийн 25 хувь, 2030 онд 30-аас доошгүй хувьд хүргэж, хамгаалалтын тогтвортой санхүүжилтийн механизмыг бүрдүүлэх	1	Тусгай хамгаалалттай газар нутаг (ТХГН)-ийн тогтвортой санхүүжилтийн механизмыг бий болгож, хамгаалалтыг сайжруулах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох	2016-2018	БОНХАЖЯ	БХБЯ	УТ, ОУБ	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж хэрэгжинэ.
		2	Хамгаалалтад хамтын менежментийг боловсронгуй болгож, төр-хувийн хэвшил, иргэний нийгмийн түншлэлээр хэрэгжүүлэх загвар төслүүдийг хэрэгжүүлж, туршлагыг түгээн дэлгэрүүлэх	2016-2025	БОНХАЖЯ	СЯ	УТ, ОНТ, ОУБ	Хустайн БНГ, Их Нартын БНГ-ын менежментийн туршлагыг түгээн дэлгэрүүлж, эхний туршилтын төслүүд хэрэгжсэн байна.
		3	Хил дамнанас ТХГН, шим мандлын дархан газрын талаар тавих хяналт, судалгааг тогтмолжуулж, мэдээллийн баазыг шинэчлэх	2016-2020	БОНХАЖЯ	ГХЯ, БХБЯ	ОУБ	Хил дамнанас ТХГН-ийн менежмент сайжирсан байна.
		4	Дэлхийн өв болон Хүн ба шим мандлын нөөц газрыг бүх нийтэд тогтвортой хөгжлийн боловсрол олгох, байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, хэмнэлттэй ногоон хэрэглээг бий болгох, байгаль хамгаалах уламжлалт ёс заншил, мэдлэгийг сэргээн төлөвшүүлэх сургалт, сурталчилгааны түшиц газар нутаг болгон хөгжүүлэх	2016-2025	БОНХАЖЯ	БСШУЯ	ОУБ	Сургалт, сурталчилгааны төвүүд байгуулагдаж, жишиг төсөл, хөтөлбөрүүд хэрэгжинэ.
		5	Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны болон ойн сан бүхий газарт ашигт малтмал эрж хайх, олборлох үйл ажиллагааг хориглох тухай хуулийн хязгаарлалтад орсон газар нутгийг нөхөн сэргээж тусгай хамгаалалтад авч, ТХГН-ийн хэмжээг нэмэгдүүлэх	2016-2025	БОНХАЖЯ	УУЯ	ХХ, УТ	Гол, мөрний урсац бүрэлдэх эхийн 60-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авсан байна.
		6	Монгол орны экосистем, амьдрах орчны тэнцлийн үнэлгээ, судалгаанд тулгуурлан шаардлагатай газруудыг эрэмбэлж тусгай хамгаалалтад авах	2016-2030	БОНХАЖЯ	БХБЯ	УТ, ОУБ	Тусгай хамгаалалтад авах нэн шаардлагатай газруудыг хамгаалалтад авч, ТХГН-ийн хэмжээг 2020 онд нийт нутаг дэвсгэрийн 25 хувь, 2030 онд 30-аас доошгүй хувьд хүргэнэ.
2.2.	Байгалийн нөөцийн үндэсний парк, байгаль, соёлын өв газар нутагт уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэхийг хязгаарлан, ногоон хөгжлийн жишиг нутаг болгон эко аялал жуулчлал, уламжлалт мал аж ахуйг хөгжүүлэх	1	Байгалийн нөөцийн үндэсний парк байгуулах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх	2016-2018	БОНХАЖЯ	АНЗД		Байгалийн нөөц газрын эрх зүйн орчин бүрдэнэ.
		2	Хан Хэнтийн дархан цаазат газар, Горхи-Тэрэлж байгалийн цогцолборт газар, тэдгээрийн орчны бүсийг байгалийн нөөцийн үндэсний парк, байгаль, соёлын өвийн дурсгалт газар нутаг болгон хөгжүүлж, экосистемийн үйлчилгээг тогтвортой хадгалах	2016-2020	БОНХАЖЯ	БСШУЯ, АНЗД	ОУБ, УТ	Байгалийн нөөцийн үндэсний парк, соёлын өвийн дурсгалт газар бий болно, ногоон хөгжлийн жишиг нутаг болно.
		3	Хангай нуруу, түүний салбар уулс, Хөвсгөл нуур орчмын ТХГН-ыг түшиглэн байгалийн нөөц, соёлын өвийн дурсгалт нутаг болгон хөгжүүлж, уул уурхайн үйлдвэрлэлийг хязгаарлаж, ногоон хөгжлийн жишиг нутаг болгох	2016-2020	БОНХАЖЯ	АНЗД	ОУБ, УТ	Байгалийн нөөцийн үндэсний парк бий болж, ногоон хөгжлийн жишиг нутаг болно.
		4	Хөдөө аж ахуйн уламжлалт өв соёлыг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх, энэ чиглэлээр жишиг төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх	2016-2030	ХХААЯ	БСШУЯ	УТ, ОНТ, ОУБ	НҮБ-ын ХХААБ-ын "Даян дэлхийн хөдөө аж ахуйн өв"-д Монгол Улсаас дэвшүүлсэн үнэт өвийг бүртгүүлж, уг өв соёлыг хамгаалах ажлыг эхлүүлсэн байна.



№	Зорилтыг хэрэгжүүлэх арга зам	№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт
2.3.	Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг сааруулах, дасан зохицох үндэсний чадавхийг бэхжүүлнэ.	1	Уур амьсгалын ногоон сан, Дасан зохицлын сан, Нүүрстөрөгчийн сан зэрэг олон улсын сангаас санхүүжилт, дэмжлэг авах зорилгоор төсөл боловсруулах, төсөл хэрэгжүүлэх чиглэлээр менежментийн чадавх бүрдүүлэх	2016-2020	БОНХАЖЯ	СЯ	ОУБ, БХС	Сангуудтай шууд харьцаж, санхүүжилт татах чадавх бүрдэж, Үндэсний хэрэгжүүлэгч нэгжтэй болсон байна.
		2	Ногоон хөгжлийг дэмжих, хүлэмжийн хийг бууруулахын зэрэгцээ байгалийн нөөцийн хэмнэлт, үр ашгийг нэмэгдүүлж, давхар үр өгөөж хүртэх боломжтой томоохон төсөл, хөтөлбөрийг олон улсын санхүүгийн механизмыг өргөн ашиглаж хэрэгжүүлэх	2017-2030	БОНХАЖЯ	СЯ, МУХАУТ	ОУБ	2-оос доошгүй томоохон төсөл хэрэгжүүлж эхэлсэн байна.
		3	Уур амьсгалын сөрөг нөлөөг сааруулахад чиглэсэн Монгол Улсын хувь нэмэр, амлалтыг үе шаттайгаар хэрэгжүүлж тайлагнах	2017-2030	БОНХАЖЯ	Яамд, ХХ	УТ, ОУБ	2030 он гэхэд агаарт ялгаруулах хүлэмжийн хийг 14%-иар (хөгжлийн өнөөгийн хандлагатай харьцуулахад) бууруулна.
		4	Дасан зохицох арга хэмжээний хувилбарыг эдийн засаг, нийгмийн голлох салбараар гаргаж, дасан зохицлын үндэсний стратеги боловсруулах	2017-2020	БОНХАЖЯ	СЯ, ХХААЯ, ЭМСЯ, БХАБ, ЭХЯ, АҮЯ, бусад яамд	ОУБ	ХАА, эрүүл мэнд, эрчим хүч, барилга зэрэг салбараар уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги гарч, арга хэмжээ хэрэгжиж эхэлнэ.
		5	Уур амьсгалын өөрчлөлтөд нэн эмзэг бүс нутгийн дасан зохицох чадавхийг нэмэгдүүлэх жишиг төслүүдийг хэрэгжүүлэх	2016-2020	БОНХАЖЯ	АНЗД	ОУБ	2-3 бүс нутгагт дасан зохицох төсөл хэрэгжинэ.
2.4.	Биологийн олон янз байдлын удмын санг хамгаалах, тархац нутаг, амьдрах орчныг тэтгэх замаар хомсдолоос сэргийлж, ашиглалтын нөөц бүрдүүлэх	1	Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангах	2016-2030	БОНХАЖЯ	АНЗД	УТ, ОУБ	Үндэсний хөтөлбөрийн төлөвлөгөө батлагдаж, биологийн олон янз байдлын хамгаалалт сайжирна.
		2	Монгол орны амьтан, ургамал, бичил биетний ангилал зүйн бүртгэлийн мэдээллийн сан бүрдүүлэх	2016-2019	БОНХАЖЯ	БСШУЯ	УТ, ОУБ	Нийт 9 чиглэлээр ангилал зүйн тайлан гарч мэдээллийн сан бүрдсэн байна.
		3	Ашигт ургамлын плантаци байгуулах, өндөр уул, говь, цөлөрхөг хээрийн бүс бүслүүрийн нэн ховор, ховор, ашиглалтад нэн өртөмтгий зүйлүүдийг тарималжуулж, нөөцийг тогтвортой ашиглах загвар төслүүдийг хэрэгжүүлэх	2017-2025	БОНХАЖЯ	АНЗД, ХХ	ХХ, ОУБ, УТ	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд говь, цөлөрхөг хээр, өндөр уулын экосистемийн ургамал, хөрс хамгаалах, ургамлыг тарималжуулах жишиг төслүүд хэрэгжиж, тогтвортой ашиглалт үүснэ.
		4	Биологийн төрөл, зүйлийн үндэсний генбанк байгуулж, удмын санг хадгалж хамгаалах	2016-2025	БОНХАЖЯ	ХХААЯ, БСШУЯ	УТ	Үндэсний генбанкттай болсон байна.
		5	Харь зүйлийн эрсдэлийн үнэлгээ, хяналтын механизмыг бүрдүүлэх	2017-2020	БОНХАЖЯ	МХЕГ, ГТЕГ	УТ, ОУБ	Харь зүйлээс экосистемд учруулж болох эрсдэлээс сэргийлэх механизм бүрдэнэ.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга зам	№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт
2.5.	Генетик нөөц, түүнтэй холбогдох уламжлалт мэдлэгийг бүртгэж үнэлэх, ашиглах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлж, нөөцийн үр өгөөжийг хүртэх нөхцөлийг хангах	1	Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэг, тэдгээрийг ашигласнаар бий болох ашгийг хүртээх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх	2016-2020	БОНХАЖЯ	ХХААЯ, ГХЯ, ОӨГ	УТ, ОУБ	Генетик нөөц болон хөдөө аж ахуйн генетик нөөцийн эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлнэ. ХХАА-н ургамлын олон улсын гэрээнд нэгдэж, холбогдох тайланг ОУБ-д гаргадаг болсон байна.
		2	Генетик нөөцийн талаарх олон улсын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд үндэсний чадавхыг бэхжүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2016-2020	БОНХАЖЯ	ОӨГ	ОУБ	Генетик нөөц, түүнийг ашиглах, үр өгөөжийг хүртэх ойлголт төлөвшиж, үндэсний чадавх бэхжинэ.
		3	Монгол орны эндемик зүйлийн генетик нөөцийг бүртгэж, генбанкны цахим мэдээлэл бий болгох	2017-2020	БОНХАЖЯ	БСШУЯ, ХХААЯ	ОУБ, УТ	Монгол орны эндемик зүйлийн болон генетик материалын бүртгэл хийгдэж, ДНХ-ийн мэдээлэл, газар зүйн заалтаар бүртгэлтэй болж баталгаажсан байна.
		4	Эдийн засгийн эргэлтэд оруулж болох бүтээгдэхүүн гаргах загвар төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих	2017-2030	БОНХАЖЯ	БСШУЯ, ХХААЯ, АҮЯ	ОУБ, УТ, ХХ	Генетик нөөц, уламжлалт мэдлэг ашиглан экспортын болон ашиг хүртэх шинэ бүтээгдэхүүнийг бий болгосон байна.
2.6.	Хувиргасан амьд организмын хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх эрсдэлийг үнэлж, урьдчилан сэргийлэх чадавхийг бэхжүүлж, импорт, худалдааны хязгаарлалт тогтоох	1	Хувиргасан амьд организм, түүнээс гаралтай бүтээгдэхүүнийг гарган авах, ашиглах, улсын хилээр нэвтрүүлэх, тээвэрлэх үйл ажиллагааг хянах цахим систем байгуулах	2017-2020	БОНХАЖЯ	СЯ, ХХААЯ, ЭМСЯ, ГТЕГ	УТ, ОУБ	Хувиргасан амьд организм, түүнээс гаралтай бүтээгдэхүүн, хүнсний нэмэлтийн талаарх нэгдсэн мэдээллийн цахим сантай болно.
		2	Тосны ургамал, шилжмэл гентэй ургамлын тариалангийн талбайд хяналтын тооллого хийж бүртгэлжүүлэх, ГМС-д оруулах, байгаль орчинд нөлөөлөх байдал, болзошгүй эрсдэлийн судалгаа хийх	2017-2020	ХХААЯ	БОНХАЖЯ	УТ, ОНТ, ОУБ	Хяналтын тооллого хийгдэж, мэдээллийг ГМС-д оруулсан байна. Холбогдох судалгаа хийгдсэн байна.
		3	Хувиргасан амьд организм тариалж байгаа тариалангийн талбайг хяналтад авч, эрсдэлийн үнэлгээ хийх	2017-2020	ХХААЯ	БОНХАЖЯ	УТ, ОНТ, ОУБ	Сэлэнгэ, Халх голын сав газарт эрсдэлийн үнэлгээ хийсэн байна.
		4	Биоаюулгүй байдлыг хангах хүрээнд шинжилгээний лаборатори, хүний нөөцийг чадавхжуулах	2017-2020	БОНХАЖЯ	БСШУЯ, ЭМСЯ	УТ, ОУБ	Шинжлэн судлах чадавх бүрдсэн байна.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга зам	№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт
2.7.	Ойжуулах ажлыг эрчимжүүлж, ойгоор бүрхэгдсэн талбайг 2030 онд нийт газар нутгийн 9.0 хувьд хүргэж, нүүрсхүчлийн хийн шингээлтийг нэмэгдүүлэх	1	Ойн тооллого хийж, нүүрсхүчлийн хийн шингээлтийг олон улсад зөвшөөрөгдсөн нийтлэг арга зүйгээр тодорхойлох, хүлэмжийн хийн худалдааг өргөтгөх ажлыг зохион байгуулах	2016-2025	БОНХАЖЯ		УТ, ОУБ	Ойн нүүрсхүчлийн хийн шингээлтийг тооцоолох чадавхийг бүрдүүлж, хүлэмжийн шингээлтийн суурь үзүүлэлтийг тодорхойлж, нүүрс-төрөгчийн арилжаа хийх боломж бүрдэнэ.
		2	Ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийг эрчимжүүлэх, иргэд, хувийн хэвшлийн идэвх санаачилгыг өрнүүлж дэмжих, ойг хомсдолд хүргэж байгаа хүчин зүйлийн нөлөөг багасгах	2016-2030	БОНХАЖЯ	АНЗД	УТ, ОУБ, ХХ	Ойн нөөцийн хомсдолыг зогсоож, ойгоор бүрхэгдсэн талбай 1.9 сая га-гаар нэмэгдэнэ.
		3	Ойн байгалийн жамаар нөхөн сэргэх явцыг дэмжих, шилмүүст модны сор, шилмэл ойн үрийн байнгын хэсэг байгуулах, үрийн болон тарьц, суулгацын байнгын нөөцийг бий болгох	2016-2030	БОНХАЖЯ		УТ, ОУБ, ХХ	Монгол орны уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон шилмүүст модны сор, шилмэл ойн үрийн болон тарьц, суулгацын нөөцтэй болно.
		4	Үйлдвэрлэлийн зориулалт бүхий өндөр бүтээмжтэй мод үржүүлгийн аж ахуй эрхлэх, байгальд ээлтэй материал, мод орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл, техник, технологи нэвтрүүлэхийг ногоон зээл, гааль, татварын бодлогоор дамжуулан дэмжих	2016-2030	БОНХАЖЯ	СЯ, АНЗД	УТ	Мод, модон материалын хэрэглээг багасгах, орлуулах боломж бий болж, модны эрэлт буурна.
		5	Барилга, зам, байгууллага, айл өрхийн хашаа зэрэг ахуйн хэрэглээнд мод хэрэглэхийг хязгаарлах, мод орлох хямд, эдэлгээтэй материалын үйлдвэрлэлийг дэмжих	2016-2030	БОНХАЖЯ	Бүх шатны ЗД	ХХ, ОУБ	Нийт сум, суурин газрын хашааны 50%-д модон материал ашиглахгүй болсон байна.
2.8.	Ой, түүний дагалт баялаг, байгалийн ургамал, амьтны хамгаалалт, зохистой ашиглалтад нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийг төлөвшүүлж, тогтвортой санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх	1	Ойн санг иргэд, нөхөрлөл, аж ахуйн нэгжид гэрээгээр эзэмшүүлэх, хамгаалалтын үр ашгийг хүртэх эрхийг хангах замаар иргэдэд түшиглэсэн хамтын менежментэд суурилсан ойн тогтвортой менежментийг бий болгох	2016-2030	БОНХАЖЯ	Бүх шатны ЗД	ОУБ, ХХ	Ойн нөхөрлөлийн үйл ажиллагаа төлөвшиж, ойгоос хамааралтай иргэдийн амьжиргаа сайжирна.
		2	Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгох	2016-2018	БОНХАЖЯ			Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийг дэмжих тогтвортой санхүүжилтийн эрх зүйн зохицуулалт бүрдсэн байна.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга зам	№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт
2.9.	Ус хангамж, ариутгах татуургын байгууламжийн хүчин чадал, бүтээмжийг нэмэгдүүлж, хүн амын 90-ээс доошгүй хувийг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усаар хангаж, сайжруулсан ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг 60-аас доошгүй хувьд хүргэх	1	Ундны ус хангамж, үйлдвэрлэлийн усны хэрэгцээг хүртээмжтэй, тогтвортой хангах үүднээс гидрогеологийн бүх төрлийн хайгуул, судалгаа (зураглал, эрэл хайгуул, горимын) явуулж, нөөц баялгийг тогтоох, ашиглалтын зохистой менежментийг бий болгох	2016-2030	БОНХАЖЯ	БХБЯ, ХХААЯ, АУЯ, УУЯ, бүх шатны ЗД	УТ, ХХ, ОУБ	Стратегийн үнэт баялаг усны нөөцийн хэмжээг тогтоох, нөөцийн хөдөлгөөнд байнгын хяналт тавих, хүн амын ундны ус хангамж, үйлдвэрлэлийн усны хэрэгцээг хүртээмжтэй, тогтвортой хангах нөхцөл бүрдэнэ.
		2	Ус хангамж, ариутгах татуургын байгууламжийн стандарт, зураг төсөл, технологийн шийдэлд шинэчлэл хийж ногоон хөгжлийн шаардлагад нийцүүлэн шинэчлэх	2016-2020	БХБЯ	СХЗГ	БННС	Ус хангамж, ариутгах татуургын байгууламжийн стандарт, зураг төсөл, технологийн шийдэл ногоон шаардлагад нийцсэн байна.
		3	Хот, суурины төлөвлөлт, дахин төлөвлөлтөд ус хангамж, ариутгах татуургын бие даасан, усны хэмнэлттэй, эргүүлэн ашиглах ухаалаг, цогц шийдлийг төлөвлөж хэрэгжүүлэх	2016-2020	БХБЯ	СЯ, АНЗД	ОНТ, ХХ	Ус хангамж, ариутгах татуургын боловсронгуй системтэй болно.
		4	Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг дэвшилтэт технологиор шинэчлэх	2016-2020	БХБЯ	НЗД	УТ	Хаягдал усыг стандартын түвшинд хүртэл цэвэрлэдэг болж, Туул голын усны бохирдол буурна.
		5	Зуслан, амралт, сувилал, аялал жуулчлал, үйлчилгээний газарт стандартын шаардлага хангасан ус хангамж, ариун цэврийн байгууламжийг үе шаттай байгуулах	2016-2025	БХБЯ	БХБЯ, БОНХАЖЯ	ХХ	ТХГН-т үйл ажиллагаа явуулах бүх ААНБ хэрэгжүүлсэн байна.
		6	Сум, суурин газарт ус хангамж, ариутгах татуургын эргүүлэн ашиглах системийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр барьж байгуулах	2016-2030	БХБЯ	АНЗД	ОУБ, ОНТ	100-аас доошгүй сум, суурин ус хангамж, ариун цэврийн төвлөрсөн байгууламжтай болно.
		7	Хот, суурины ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс, тэжээгдлийн мужийн дэглэмийг мөрдүүлж, эдгээр бүсэд орших өрх, ААНБ-ыг ариутгах татуургын нэгдсэн сүлжээнд холбох	2016-2030	АНЗД	БХБЯ, БОНХАЖЯ	ОНТ, ХХ	Улаанбаатар хот болон бусад хот, суурины ус хангамжийн эх үүсвэр бохирдох эрсдэл буурна.
2.10.	Үйлдвэрлэлийн зориулалтаар газрын доорх цэнгэг усны ашиглалтыг хязгаарлан, хаягдал усыг стандартын түвшинд хүртэл цэвэрлэж дахин ашиглах, эргүүлэн ашиглах технологи нэвтрүүлэхийг дэмжих	1	Ус хэмнэх, саарал ус болон цэвэрлэсэн усыг дахин ашиглах техник, технологийн хэрэглээг нэмэгдүүлэх эрх зүйн болон эдийн засгийн хөшүүргийг боловсронгуй болгож дэмжих	2016-2025	БОНХАЖЯ	БХБЯ, АНЗД, ИТХ	УТ	Усны дахин ашиглалт, үр ашиг нэмэгдэж, усны нөөцийн хэмнэлт бий болгох эрх зүйн орчин бүрдсэн байна.
		2	Бохирдуулагч нь төлбөр төлөх болон зөвшөөрлийн механизмаар дамжуулан үйлдвэрлэлийн усыг эргүүлэн ашиглах, цэвэрлэж дахин ашиглахыг нэмэгдүүлэх	2016-2030	БОНХАЖЯ	ХХААЯ, УУЯ, АНЗД, МҮХАУТ	ХХ	Үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа усны 30-аас доошгүй хувийг эргүүлэн ашигладаг болно.
		3	Хот, суурин газрын ахуйн хаягдал усыг стандартын түвшинд хүртэл цэвэрлэж, үйлдвэрлэлд эргүүлэн ашиглахыг дэмжих	2017-2025	БХБЯ	БОНХАЖЯ, АУЯ, ЭХЯ, АНЗД	ХХ, ОУБ	Цэвэрлэх байгууламжаас гарах цэвэрлэсэн ус, лагийн дахин ашиглалт нэмэгдэнэ.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга зам	№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт
2.11.	Хур бороо, цас, үерийн усыг хуримтлуулан ашиглах санаачилга, гадаргын усны хуримтлал бий болгон ашиглах төсөл, газрын доорх усыг нөхөн сэргээх, нөөцийг нэмэгдүүлэх туршилт судалгааг хөхиүлэн дэмжих	1	Хур бороо, цас, мөсний усны нөөцийг хуримтлуулах хөв, усан сан байгуулахыг дэмжих	2016-2030	БОНХАЖЯ	АНЗД	УТ, ОНТ, ХХ	Усны нөөцийн эх үүсвэрүүд бий болж, усны хангамж сайжирна.
		2	Усыг хуримтлуулж нөөцийг нэмэгдүүлэх, газрын доорх усны ордыг зориудаар цэнэглэж арвижуулах, нөхөн сэргээх туршилт судалгаа явуулах	2016-2018	БОНХАЖЯ	БСШУЯ	УТ	Усыг нөөцлөх жишиг төслүүд хэрэгжинэ.
		3	Цас, борооны усыг нөөцлөх, хөрсөнд шингээх технологийг ус хангамж, хөдөө аж ахуй, газар тариалан зэрэг салбарууд, боломжтой газруудад нэвтрүүлэх	2017-2030	БОНХАЖЯ	ХХААЯ, АНЗД	УТ, ОНТ	Газрын доорх усны нөөцийн нөхөн сэлбэлдлийн хувь дээшилнэ.
		4	Барилга байгууламжийн дээврийг хур борооны усыг цуглуулах боломжтой болгож, өрх, ААНБ-ын ахуйн хэрэгцээ, ногоон байгууламжийн усалгаанд хэрэглүүлж хэвшүүлэх	2016-2030	БХБЯ	БОНХАЖЯ, АНЗД, ИТХ	УТ, ХХХ	Хур борооны усыг цуглуулж, ашигладаг өрх, ААНБ-ын тоо нэмэгдэнэ.
2.12.	Эдийн засгийн хурдацтай өсөлт, уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд хүний үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулах хор уршгийг багасгах, арилгах нөхцөлийг бүрдүүлж, хуурайшил, газрын доройтол, цөлжилтийн сөрөг үр дагаврыг бууруулах	1	Говийн баянбүрдийг хамгаалах, сэргээх арга хэмжээг авч хэрэгжүүлэх	2017-2025	АЗД	БОНХАЖЯ	УТ, ОНТ, ХХ	Говийн аймгууд 2-оос доошгүй баянбүрдийг хамгаалалтад авсан байна.
		2	Бэлчээрийн менежментийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох	2016-2020	ХХААЯ	БОНХАЖЯ, БХБЯ	УТ	Холбогдох эрх зүйн орчин бүрдсэн байна.
		3	Талхлагдсан бэлчээрийг мал бэлчээрлэхээс чөлөөлж сэлгэх, нөхөн сэргээх, тарималжуулах, тордож сайжруулах отрын тусгай хэрэгцээний бэлчээрийг бий болгох	2016-2030	ХХААЯ	Бүх шатны ЗД	УТ, ОНТ, ХХ	Сум бүр нийт бэлчээрийн талбайн 10 хүртэл хувийг сэлгээх, нөхөн сэргээх, отрын бүс бий болгох ажлыг зохион байгуулсан байна. Жилд 2000-аас доошгүй га талбайг сайжруулна.
		4	Бэлчээрийн даац, нөхөн сэргэх чадавхид тохирсон малын тоо, бүтцийг төрөл тус бүрээр бүсчлэн тогтоож, даацад тохирсон аж ахуй эрхлэх механизмыг татварын болон эдийн засгийн хөшүүрэг ашиглан бүрдүүлэх	2016-2020	ХХААЯ	Бүх шатны ЗД, БОНХАЖЯ	УТ, ОНТ, ХХ, ОУБ	Бүх сумдад бэлчээрийн даацад тохирсон мал аж ахуйн зохистой менежментийг бүрдүүлсэн байна. Татварын болон эдийн засгийн хөшүүргийг ашиглах боломж бүрдэнэ.
		5	Газрын чанарын төлөв байдлын хяналт-шинжилгээний сүлжээг боловсронгуй болгох	2016-2020	БОНХАЖЯ	АНЗД, БХБЯ	УТ, ОУБ	Газрын доройтол, цөлжилтийн хяналт-шинжилгээ, мэдээллийн цогц сүлжээ бүрдэнэ.
		6	Хот суурины ойролцоох бүс нутагт эрчимжсэн аж ахуй эрхлэх газар зохион байгуулалтыг тодорхой болгож, тэдгээрийг татвар, зээлийн бодлогоор дэмжин хөгжүүлэх	2016-2030	ХХААЯ, БХБЯ	СЯ, АНЗД	ОНТ, ХХ	Эрчимжсэн аж ахуй эрхлэхийг дэмжих эрх зүйн зохицуулалт бүрдэж, зээлийн эргэлтийн сангийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.
		7	Авто зам, төмөр зам дагууд болон байгалийн бүс бүслүүр шилжих зааг, цөлжилтөд хүчтэй өртөж байгаа газар нутагт цөлжилтийг сааруулах ойн зурвас байгуулах, бэлчээрийг сэргээх арга хэмжээ авч хэрэгжүүлэх	2016-2030	БОНХАЖЯ, ЗТЯ	БХБЯ, УБТЗ, МТЗ	ОУБ, УТ, ХХ	Цөлжиж доройтсон газар нутагт 1000-аас доошгүй га талбайд ойн зурвас байгуулна.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга зам	№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт
2.13.	Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон, бохирдолд өртсөн, атаршсан газрын 70-аас доошгүй хувийг нөхөн сэргээж, аж ахуйн зориулалтаар дахин ашиглахад чиглэсэн үйл ажиллагааг дэмжих	1	Байгаль орчинд учруулсан хохирол, нөхөн төлбөр, нөхөн сэргээх газар, түүний зардлын талаарх нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх	2016-2018	БОНХАЖЯ	БСШУЯ	УТ	Байгаль орчны хохирол, нөхөн сэргээлтийн мэдээллийн цахим сан бүрдэж, олон нийтэд нээлттэй болно.
		2	Газрын доройтолд орсон, эвдэрсэн газар нутгийг эрэмбэлэн газрыг нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах	2016-2030	УУЯ БОНХАЖЯ	БХБЯ, ХХААЯ, АНЗД	ХХ, ОНТ, УТ	Эвдэрсэн газар нутгийн 70%-иас доошгүйг нөхөн сэргээсэн байна.
		3	Ашигт малтмалын төрөл, олборлох, боловсруулах технологийн онцлогийг тусгасан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх Европын холбооны болон бусад орны стандартыг нутагшуулж мөрдүүлэх	2016-2018	БОНХАЖЯ	СХЗГ	ОУБ	Стандарт батлагдаж мөрдөгдөнө.
		4	Уурхайн хаалт, нөхөн сэргээлт хийгдээгүйгээс болон хууль бусаар ашигт малтмал олборлосны улмаас байгаль орчинд учирсан хохирлыг тооцох аргачлал, жишиг үнэлгээг нарийвчлан боловсруулж, хохирлыг нөхөн төлүүлэх, нөхөн сэргээх боломжийг бүрдүүлэх	2016-2017	БОНХАЖЯ	УУЯ	ОУБ	Аргачлал боловсруулж, 2-оос доошгүй газарт байгаль орчны хохирлыг тооцож, туршсан байна.
2.14	Байгалийн баялгийг зохистой ашиглах эрх зүйн зохицуулалт, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулах механизмыг боловсронгуй болгох	1	Байгалийн баялгаас олж байгаа ашиг, орлогын тодорхой хувь болон учруулсан хохирлын нөхөн төлбөрийн орлогыг тухайн нөөцийг нөхөн сэргээх, байгаль орчны бохирдол, доройтлыг арилгахад зарцуулж хэвших	2016-2020	Бүх шатны ЗД	БОНХАЖЯ	ОНТ	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хуульд заасан хувь хэмжээ, учруулсан хохирлын нөхөн төлбөрийн орлогыг нөхөн сэргээх, судлах, хамгаалах, бохирдол, доройтлыг бууруулахад зарцуулдаг тогтолцоо хэвшсэн байна.
		2	Байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх цагдаагийн байгууллага, шүүхийн шинжилгээний төвийг чадавхжуулах	2017-2019	ХЗЯ	БОНХАЖЯ	УТ	Байгалийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх чадавх сайжирч, хэргийн тоо буурах, байгаль орчинд учруулах хохирлыг багасгах нөхцөл бүрдэнэ.
		3	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшлийн газар дээрээ өөрийн хөрөнгөөр тарьж ургуулсан ой, ургамал, өсгөн үржүүлсэн ан амьтныг өмчлүүлэх, эзэмшүүлэх замаар хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх	2016-2025	БОНХАЖЯ	АНЗД, БХБЯ	УТ, ХХ	Энэ чиглэлд хөрөнгө оруулалтыг 10 хувиар нэмэгдүүлсэн байна.

## STRATEGIC OBJECTIVE #3

INCREASE INVESTMENT IN NATURAL  
CAPITAL, HUMAN DEVELOPMENT  
AND CLEAN TECHNOLOGY BY  
INTRODUCING FINANCING, TAX,  
LENDING AND OTHER INCENTIVES  
FOR SUPPORTING A GREEN  
ECONOMY.



№	Зорилтыг хэрэгжүүлэх арга зам	№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт
3.1.	Дотоодын нийт бүтээгдэхүүний 2-оос доошгүй хувийг жил бүр ногоон хөгжилд зарцуулж, нэгж бүтээгдэхүүнд ногдох нүүрсхүчлийн хийн ялгарлыг бууруулах, бүтээмжийг дээшлүүлэх, байгалийн нөөц ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтыг өсгөх	1	Байгаль хамгаалах сангийн үйл ажиллагааг өргөжүүлж, Олон улсын сан (Уур амьсгалын ногоон сан, Дасан зохицлын сан зэрэг)-гийн Үндэсний хэрэгжүүлэгч нэгж болгох	2016-2018	БОНХАЖЯ	СЯ	БХС, ОУБ	Байгаль хамгаалал, ногоон хөгжлийн чиглэлээрх олон улсын сангаас итгэмжлэгдсэн Үндэсний хэрэгжүүлэгч нэгжтэй болно.
		2	Бэлчээрийн талбайн нүүрсхүчлийн хийн шингээлтийг олон улсын нийтлэг арга зүйгээр тодорхойлж, хүлэмжийн хийн худалдаанд оролцох арга замыг эрэлхийлэх	2017-2025	БОНХАЖЯ	Банкууд	БХС, ОУБ	Бэлчээрийн нүүрсхүчлийн хийн шингээлтийг тооцоолох чадавхийг бүрдүүлж, хүлэмжийн шингээлтийн суурь үзүүлэлтийг тодорхойлж, нүүрстөрөгчийн арилжаа хийх боломж бүрдэнэ.
		3	Цэвэр технологи, инновацийг бий болгоход чиглэсэн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг жил бүрээр хийж, хөрөнгө оруулалтыг дэмжиж, технологийн туршилт судалгааны санхүүжилтийг нэмэгдүүлэх	2017-2025	СЯ, БСШУЯ	Яамд, ШУБ, ХХ	УТ, ХХ	Цэвэр технологи, инновацийн төлөвлөлт жил бүр гардаг болно. Төр, хувийн хэвшлийн түншлэл, концессын гэрээгээр хийгдэх үйл ажиллагаа нэмэгдсэн байна.
		4	Усны хэрэглээг бүрэн тоолууржуулж, нөөцийг хэмнэлттэй зарцуулах хэвшлийг бий болгох	2016-2022	БОНХАЖЯ	АНЗД, ХХ	ОНТ, ХХ	Хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээ төлөвшинө.
		5	Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэлд зарцуулах эрчим хүч, ус болон бусад байгалийн нөөцийн хэрэглээний үзүүлэлтийг тооцох	2016-2030	БСЕГ	АУЯ, МҮХАҮТ	ОУБ, УТ	Үндэсний үйлдвэрлэгчийн нөөц баялаг ашиглалт, бохирдлын индикатор үзүүлэлтүүд өндөр хөгжилтэй орнуудын түвшинд хүрсэн байна.
3.2	Байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл, хэрэглээний дадлыг төлөвшүүлэх, дэмжих, байгалийн нөөцийн ашиглалтын бүтээмжийг нэмэгдүүлэх эдийн засгийн хөшүүргийг бүрдүүлэх	1	Байгаль орчинд ээлтэй, цэвэр үйлдвэрлэл, хэмнэлттэй хэрэглээг дэмжих урамшуулал, эдийн засгийн хөшүүргийг бий болгож хэрэгжүүлэх	2016-2030	БОНХАЖЯ	СЯ, МҮХАҮТ	ОУБ, УТ	Эко тэмдэг, шошго, ногоон гэрчилгээ зэрэг урамшууллын механизмууд бий болсон байна.
		2	Тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээ (ТҮХ)-г төлөвшүүлэх хөтөлбөр болон ногоон эдийн засгийн сургалтын дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	2016-2025	АУЯ, БОНХАЖЯ	ХХААЯ, БХБЯ, ЭХЯ, ЗТЯ, УУЯ, БСШУЯ, ШӨХТГ, АНЗД, МҮХАҮТ	ОУБ, УТ	ТҮХ-ний хөтөлбөр, ногоон эдийн засгийн сургалтын дэд хөтөлбөр гарсан байна. Тогтвортой хөгжлийн гол цөм болсон нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай үйлдвэрлэл, хэрэглээ төлөвшсөн байна.
		3	Байгальд ээлтэй техник технологийн үзэсгэлэн худалдааг жил бүр зохион байгуулж, гадаад, дотоод зах зээлд сурталчлах	2016-2030	БОНХАЖЯ	МҮХАҮТ	УТ	Шинжлэх ухааны ололт амжилт, шинэ техник, технологийг бизнест нэвтрүүлэх боломж нэмэгдэнэ.
		4	Төв, орон нутгийн төсвийн байгууллагуудын эрчим хүчний хэрэглээний үр ашгийг дээшлүүлэх зорилгоор ЭСКО хөрөнгө оруулалтыг татан техникийн шинэчлэл хийж, гарсан хэмнэлтээс эргэн төлөх журам боловсруулж хэрэгжүүлэх	2016-2030	ЭХЯ	СЯ	УТ, ХХ	ЭСКО компаниудыг дэмжихийн зэрэгцээ төсвийн байгууллагуудын эрчим хүчний хэрэглээний үр ашиг дээшлүүлнэ.
		5	Ногоон зээл, ногоон санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх асуудлыг төрийн мөнгөний бодлогоор дэмжин урамшуулах бодлогын судалгаа хийж, шийдвэр гаргах	2016-2020	МБ	СЯ	ОУБ	Ногоон хөгжлийг дэмжих эдийн засгийн хөшүүргийн судалгааны үр дүн гарсан байна.



№	Зорилтыг хэрэгжүүлэх арга зам	№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт
		6	Байгаль орчинд ээлтэй, өндөр үр ашигтай техник, тоног төхөөрөмжийн импортын татварыг чөлөөлөх хүрээг өргөжүүлэх	2017-2030	СЯ	БОНХАЖЯ	УТ	Байгаль орчинд ээлтэй техник, тоног төхөөрөмжийн импортын татвараас чөлөөлөгдөх хүрээг өргөжүүлсэн байна.
		7	Байгаль орчин, эдийн засгийн дансны системийг үе шаттайгаар байгуулах	2016-2027	БСЕГ	БОНХАЖЯ, СЯ, ГТЕГ	УТ, ОУБ	Эдийн засаг, байгаль орчны хоорондын харилцаа, байгалийн нөөц ашиглалтын үнэлгээ, байгаль орчинд учирсан хохирлыг тодорхойлох боломжтой болно.
3.3	Ойн ус тогтоон барих, нүүрсхүчлийн хий шингээх, голын татмын ус хуримтлуулах, цэвэршүүлэх чадавх зэрэг экосистемийн үйлчилгээг тэтгэн, үр өгөөжийг үнэлж, олон нийтэд таниулах, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хөрөнгө оруулалтыг 20 хувиар нэмэгдүүлэх	1	Ус, хөрс, ой зэрэг байгалийн нөөц баялгийн болон экосистемийн үйлчилгээний үнэ цэнийг үнэлэх аргачлалыг олон улсын туршлагад тулгуурлан боловсруулж эдийн засгийн үнэлгээ гарган, үр өгөөжийг олон нийтэд сурталчлан таниулах	2016-2025	БОНХАЖЯ	СЯ	ОУБ	Байгалийн нөөц баялгийн эдийн засгийн үр өгөөжийг тооцоолж гаргана. Олон нийт экосистемийн үйлчилгээг талаар мэдлэгтэй болно.
		2	Экосистемийн үйлчилгээний төлбөрийг тогтоох судалгаа хийж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох	2017-2025	БОНХАЖЯ	МҮХАУТ, яамд	ОУБ	Судалгаа хийгдэж, холбогдох дүрэм, журам боловсронгуй болсон байна.
		3	Байгаль хамгааллын төрийн байгууллагын тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага, хувийн хэвшилд тодорхой нөхцөл, үе шаттайгаар хариуцуулан гүйцэтгүүлэх	2016-2025	БОНХАЖЯ	МҮХАУТ		Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төр, хувийн хэвшлийн түншлэл өргөжинө.
3.4	Байгаль орчинд халтай үйлдвэрлэл, үйлчилгээ, бараа, бүтээгдэхүүний импорт, хэрэглээг багасгахад чиглэсэн ногоон татвар бий болгох	1	Аж ахуйн нэгжийн татварын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр орлогын албан татварыг хүлэмжийн хийн ялгаруулалт, эрчим хүчний үр ашиг, шавхагддаг түлшний хэрэглээ, хог хаягдал, бохирдол зэрэг байгаль орчны сөрөг нөлөөллийг тооцсон татварт шилжүүлэх судалгаа хийх	2016-2020	СЯ	БОНХАЖЯ, МҮХАУТ	ОУБ	Ногоон татварт шилжих бодлогын судалгаа хийгдсэн байна.
		2	Ногоон эдийн засгийг татварын бодлогоор дэмжих тогтолцоог бий болгож, экосистемийн үйлчилгээний төлбөр, ногоон татварын эрх зүйн орчныг бүрдүүлэх	2016-2020	БОНХАЖЯ	СЯ		Эрх зүйн орчин болон татварын механизм тодорхой болж, татварын хэрэгслээр дамжуулан ногоон эдийн засгийн бодлогыг дэмжинэ. Ногоон татварыг тооцох хэмжүүр, шалгуур гарсан байна.
		3	Аливаа татаасын байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл болон байгаль орчинд халтай үйл ажиллагаанд олгодог татаасыг дэс дараатай бууруулж, ногоон хөгжил, ядуурлыг бууруулах үйл ажиллагаанд шилжүүлэх судалгаа хийх	2016-2017	СЯ	Яамд	ОУБ	Байгаль орчинд халтай үйл ажиллагааны татаасыг бууруулах үндэслэл гарна.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга зам	№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт
3.5	Олон улсын худалдааны гэрээ, хэлэлцээрт ногоон хөгжлийн зарчмыг тусган бага нүүрстөрөгч бүхий эрчим хүчний хэмнэлттэй технологийн худалдааг дэмжих	1	Байгаль орчинд ээлтэй бараа, технологи дамжуулалт, мэдээлэл солилцох, хөрөнгө оруулалтын урсгалыг нэмэгдүүлэх худалдааны хэлэлцээрийг дэмжиж ажиллах	2016-2020	СЯ	ГХЯ, БОНХАЖЯ	УТ, ОУБ	Олон талт болон хоёр талт гэрээ хэлэлцээрт байгаль орчинд ээлтэй байх шалгуур тавигдсан байна.
		2	Хөгжингүй орнуудын худалдааны гэрээ хэлцэлд тавьж байгаа шаардлагын нэг нь тухайн нийлүүлж байгаа бүтээгдэхүүн байгаль орчинд халгүй байдлаар үйлдвэрлэгдсэн, аюулгүй эсэхэд нотолгоо баталгаа гаргуулахад оршиж байгааг харгалзан гадаад худалдаа, хамтын ажиллагааны хүрээнд үйлдвэрлэгч, экспортлогч-бизнесийнхэнд өмчийн хэвшил үл харгалзан чадавхийг бий болгох, дээшлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх	2016-2020	АҮЯ	ГХЯ, БОНХАЖЯ, СЯ	УТ, ОУБ, ХХ	Бараа, бүтээгдэхүүнийг байгаль орчны талаас нь үнэлэх, баталгаа гаргах чиглэлээр үндэсний чадавх бий болсон байна.
3.6	Засгийн газрын худалдан авалтын 20-иос доошгүй хувийг байгаль орчинд ээлтэй, үр ашигтай, хэмнэлттэй бараа, ажил, үйлчилгээ авахад зарцуулах	1	Засгийн газрын тогтвортой/ногоон худалдан авалтыг хэрэгжүүлэх судалгаа (эрх зүйн орчны, тэргүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ) хийх	2016	СЯ	БОНХАЖЯ	ОУБ	Эрх зүйн орчныг шинэчлэх үндэслэл, судалгаа хийгдсэн байна.
		2	Засгийн газрын худалдан авалтад ногоон хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох	2016-2018	СЯ	ХААГ	УТ	Эрх зүйн орчин бий болж хэрэгжинэ. Ногоон худалдан авалтын нийтлэг журам батлагдсан байна. ТЕЗ-ийн багцыг батлахдаа "Ногоон худалдан авалт"-ын хувь хэмжээг тогтоодог болно.
		3	Зах зээлд нийлүүлж байгаа ногоон бараа, бүтээгдэхүүний судалгааг хийж, бүтээгдэхүүн (барилгын материал зэрэг)-ий мэдээллийн сан үүсгэх, мэдээллийг Засгийн газрын хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд ашиглаж эхлэх	2016-2018	БОНХАЖЯ	ХААГ, МҮХАҮТ	ОУБ	Зах зээлийн эрэлт, нийлүүлэлт тэлнэ. Ногоон бараа, бүтээгдэхүүний Засгийн газрын худалдан авалтад эзлэх хувь нэмэгдэнэ.
		4	Төрийн байгууллагын худалдан авалтыг ногоон худалдан авалтад үе шаттайгаар шилжүүлэх	2017-2030	Бүх шатны ТЕЗ	ХААГ, СЯ	УТ	ЗГ-ын урсгал зардлын худалдан авалтын 20 хувь нь ногоон худалдан авалт болсон байна.
		5	Олон улсад тогтсон "Ногоон оффис" аргачлалын дагуу оффисын тоног төхөөрөмж, хэрэглээний материалыг худалдан авах ногоон худалдан авалтын нийтлэг журам, шалгуурыг боловсруулж хэрэгжүүлэх	2016-2030	СЯ	Бүх шатны ТЕЗ, МҮХАҮТ	УТ	Холбогдох судалгаа хийгдэж, шалгуур үзүүлэлт гарсан байна. Хэмнэлт бий болохын зэрэгцээ хаягдал багасна.
		6	Үндэсний үйлдвэрлэгчийн ногоон бүтээгдэхүүнийг төсвийн хөрөнгөөр эн тэргүүнд худалдан авах эрх зүйн тогтолцоо бий болгох	2016-2030	СЯ	ХЗЯ	УТ	Эрх зүйн тогтолцоо бий болсноор үндэсний ногоон бүтээгдэхүүний зах зээл бий болно.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга зам	№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт
3.7	Банк, санхүүгийн байгууллагын байгаль орчинд ээлтэй тогтвортой санхүүжилтийн тогтолцоог бий болгож, аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн хариуцлагыг өндөржүүлэх	1	Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн зарчмуудыг тодорхойлж банк, санхүүгийн системд нэвтрүүлэх	2016-2017	МБХ	БОНХАЖЯ, МБ, банкууд	ОУБ	Тогтвортой санхүүжилтийн тогтолцоо банк, санхүүгийн системд нэвтэрсэн байна. Аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн хариуцлагыг тогтвортой санхүүжилтийн тогтолцоогоор дамжин өндөржүүлнэ.
		2	Байгаль орчин, нийгэмд ээлтэй үйл ажиллагааг дэмжих төр, хувийн хэвшлийн менежментийг хослуулсан ногоон зээлийн санг бий болгох	2016-2025	МБХ, банкууд, БОНХАЖЯ	СЗХ, МБ, АНЗД, ХХ, ОУБ, МҮХАҮТ	ОУБ, ХХ	Ногоон зээлийн сан бий болж, байгаль орчин, нийгэмд ээлтэй хөрөнгө оруулалтыг дэмжих тогтолцоо бий болно. Ногоон бизнес эрхлэгчдэд зориулсан хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл олгох механизм бий болно.
		3	Банк, санхүүгийн салбарын зохицуулагч байгууллагууд өөрсдийн тогтвортой санхүүжилтийн бодлого, журмыг батлан хэрэгжүүлж эхлэх	2016-2018	МБ, СЗХ	ОУБ, Мэргэжлийн холбоод		Банк, санхүүгийн салбарын зохицуулагч байгууллагуудын үйл ажиллагаанд тогтвортой санхүүжилтийн тогтолцоо амжилттай нэвтэрсэн байна.
		4	Банк, санхүүгийн байгууллагын тогтвортой санхүүжилтийн тогтолцоог дэмжих эрх зүйн орчин, хяналт, үнэлгээ, урамшууллын механизмыг бий болгох	2016-2020	МБ СЗХ	Мэргэжлийн холбоод, ОУБ		Зохицуулагч байгууллагуудаас банк санхүүгийн байгууллагуудын тогтвортой санхүүжилтийн хэрэгжилтийг хянах, үнэлэх, урамшуулах механизм бий болсон байна. Зах зээлийн эрэлтийн судалгаа хийгдсэн байна.
		5	Бизнесийн салбарын мэргэжлийн холбоодыг байгаль орчин, нийгэмд ээлтэй санаачилга гаргах, тогтвортой санхүүжилтийн зарчмуудад нэгдэн хамтран ажиллахыг дэмжиж, чиглүүлэн зохион байгуулах	2017-2025	АҮЯ, УУЯ, ЭХЯ, ХХААЯ, БХБЯ, ЗТЯ	МХБ, БОНХАЖЯ, МҮХАҮТ, АНЗД	ОУБ	Эдийн засгийн гол салбарууд өөрсдийн байгаль орчин, нийгэмд ээлтэй зарчмуудыг баталж, амжилттай нэвтрүүлж эхэлсэн байна. Салбарын зарчмууд ТоС-ийн зарчмуудтай уялдсан байна.
		6	Байгаль орчин, нийгэмд ээлтэй зарчмуудын хэрэгжилтийг хянах, үнэлэх, чадавхжуулах, хамтран ажиллах механизмыг бий болгож дэмжин ажиллах	2017-2030	АҮЯ, УУЯ, ЭХЯ, ХХААЯ, БХБЯ, ЗТЯ	Мэргэжлийн холбоод, БОНХАЖЯ, АНЗД	ОУБ, ХХ	Бизнесийн салбарын байгаль орчин, нийгэмд ээлтэй зарчмуудын хэрэгжилтийг хянах, үнэлэх, чадавхжуулах, дэмжих механизм бий болж, амжилттай хэрэгжсэн байна.
3.8	Ногоон хөгжлийн үзүүлэлтийг Үндэсний тооцооны системд тусган, байгаль орчноос нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулах хувь нэмрийг тооцох	1	Ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг боловсруулж гаргах	2016	БСЕГ	БОНХАЖЯ	ОУБ	Ногоон хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийг гаргаж, үнэлгээнд ашигладаг болно.
		2	Байгалийн баялгийн нөөц, түүний ашиглалтын талаарх албан ёсны статистик бүртгэлийн хамрах хүрээг өргөжүүлэх, байгалийн нөөцийн хомсдол, бохирдлын үзүүлэлтийг үндэсний хөгжлийн үзүүлэлтэд тусгах	2016-2020	БСЕГ	БОНХАЖЯ	ОУБ	Байгалийн нөөц баялаг, байгалийн нөөцийн хомсдол, бохирдлын үзүүлэлтүүд үндэсний тооцооны системд тусгагдана.
		3	Үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл, бохирдол, хаягдлын болон тухайн үйл ажиллагааны эдийн засгийн үр ашгийг илэрхийлэх үзүүлэлтийг бий болгох	2016-2025	БСЕГ	АҮЯ, ЭХЯ, БХБЯ, ЗТЯ, ХХААЯ, БОНХАЖЯ, ЭМСЯ	ОУБ	Үйлдвэрийн эдийн засгийн үр ашгийг тооцох асуудал шийдэгдсэн байна.

## STRATEGIC OBJECTIVE #4

ENGRAIN A GREEN LIFESTYLE BY  
REDUCING POVERTY AND  
PROMOTING GREEN JOBS.



№	Зорилтыг хэрэгжүүлэх арга зам	№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт
4.1	Төр, хувийн хэвшлийн туншлэлийн хүрээнд байнгын ажлын байрыг нэмэгдүүлж, хөдөлмөрийн насны хүн амын 80-аас дээш хувь нь зохистой хөдөлмөр эрхэлж, баталгаатай орлоготой болох нөхцөлийг бүрдүүлэх	1	Зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого батлуулж, хэрэгжилтийг хангах	2016-2017	ХЯ	Яамд	УТ	Зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого батлагдаж, иргэд баталгаатай орлоготой болох нөхцөл нэмэгдэнэ.
		2	Зохистой, ногоон ажлын байрны шалгуур үзүүлэлтийг боловсруулж, статистик мэдээлэл бий болгох	2016-2020	БСЕГ	ХЯ, ИБЕГ	ОУБ	Ногоон ажлын байрыг тооцох аргачлал батлагдаж, ногоон ажлын байрны цахим сан, статистик мэдээлэл бүрдэнэ.
		3	Ногоон ажлын байрыг шинээр бий болгосон, тогтвортой хадгалсан ажил олгогчийг татвар, зээлийн бодлогоор дэмжих	2017-2025	ХЯ	СЯ	УТ	Ногоон ажлын байрны тоо 2016 онтой харьцуулахад 2020 онд 10%, 2030 онд 30%-иар өссөн байна. Ногоон ажлын байрыг шинээр бий болгох, тогтвортой хадгалсан ажил олгогчийг дэмжих эрх зүйн орчин боловсронгуй болсон байна.
		4	Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагааг ногоон үйлдвэрлэл, ногоон ажлын байрыг дэмжихэд түлхүү чиглүүлэх	2016-2025	ХЯ	БОНХАЖ, АУЯ, ХХААЯ	УТ, ОУБ	ААНБ, иргэнд Засгийн газрын тусгай сангуудаас зээл, санхүүгийн дэмжлэг олгох шалгуур, нөхцөлд ногоон ажлын байр, ногоон үйлдвэрлэлийн зарчмыг тусгаж, хэвшүүлсэн байна.
		5	Зорилтот бүлгийн иргэдэд (ажилгүй, хөгжлийн бэрхшээлтэй, тэтгэврийн насны иргэд болон эмэгтэйчүүд) үзүүлэх хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг ногоон ажлын байрыг дэмжих санал санаачилгатай уялдуулж хэрэгжүүлэх	2017-2030	ХЯ	ХАХНХЯ, БОНХАЖЯ	УТ	Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр төрөөс хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн хүрээнд ногоон ажлын байр бий болсон байна. Зорилтот бүлгийн хүн амын хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна.
		6	Ажил олоход хүндрэлтэй иргэдийг (5 зорилтот бүлэг) нийгэмшүүлэх, мэргэжил эзэмшүүлж ажилтай болгоход дэмжлэг үзүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	2016-2025	ХЯ	ХАХНХЯ, БСШУЯ, АНЗД	УТ, ОУБ	Хөтөлбөрт жилд дунджаар 1000-аас доошгүй зорилтот бүлгийн иргэдийг хамруулж, ажлын байртай болгосон байна.
		7	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх замаар эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломж, бүтээмжийг нэмэгдүүлэх	2016-2020	ХЯ	ХАХНХЯ, БСШУЯ, АНЗД	УТ	Эдийн засаг, нийгмийн хөгжилд оролцох эмэгтэйчүүдийн оролцоо нэмэгдэж, хувь хүн, өрхийн орлогын түвшин дээшилнэ.
4.2	Олон улсын жишигт нийцсэн чанартай боловсролыг эх орондоо эзэмшиж, өрсөлдөх чадвартай, мэргэшсэн чадварлаг ажиллах хүчинтэй болж, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх	1	Ажиллах хүчний дунд, урт хугацааны хөдөлмөрийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаа хийх	2016-2017	ХЯ		УТ, ОУБ	Ажиллах хүчний судалгааг тогтмолжуулж, бодлого төлөвлөлтөд ашиглаж хэвшинэ.
		2	Ажиллах хүчний төлөвлөлтийг эдийн засгийн бодит салбаруудаар хийж эрэлтэд нийцүүлэн боловсон хүчнийг бэлтгэх тогтолцоо бий болгох	2016-2025	ХЯ	БСШУЯ	ХЭДС	Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтэд суурилсан хүний нөөцийг бэлтгэх тогтолцоо бий болсон байна.
		3	МСҮТ-ийг үйлдвэрлэл, үйлчилгээний томоохон бааз суурийг түшиглэн хөгжүүлж, өрсөлдөх чадвартай, мэргэжилтэй ажиллах хүчнийг бэлтгэх	2016-2025	ХЯ	БСШУЯ	УТ, ОУБ	Эдийн засгийн тэлэлт, үйлдвэрлэлийн хөгжлийн дүнд бий болох ажиллах хүчний эрэлтэд нийцсэн ур чадвартай хүний нөөцийг бэлтгэж гаргана.
		4	Оюутны үйлдвэрлэлийн дадлагын чанарыг сайжруулж, ур чадвартай, өрсөлдөхүйц мэргэжилтэн бэлтгэх	2016-2020	БСШУЯ		УТ, ХХ	Үйлдвэрлэлийн дадлага хийх материаллаг бааз бүрдэж, чанар сайжирч, их, дээд сургууль төгсөгчдийн ур чадвар сайжирч, хөдөлмөр эрхлэлт нэмэгдэнэ.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга зам	№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт
4.3	Амьжиргааны олон талт эх үүсвэрийг бий болгон, нийгмийн хамгааллын суурийг өргөжүүлэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, дундаж давхаргыг бэхжүүлэх	1	Цалин хөлсний тогтолцоог бүтээмж, ур чадварт суурилсан байхаар боловсронгуй болгох	2016-2020	ХЯ	ХХ		Ажилтны ур чадвар, ажил, мэргэжлийн зэргийн түвшинтэй уялдсан, бүтээмжид суурилсан цалин хөлсний үнэлгээний систем бий болсон байна. Ажилтнуудын цалингийн хэмжээ амьжиргааны дунд түвшинг хангах түвшинд хүрсэн байна.
		2	Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлж, хувийн хуримтлал бий болгохыг дэмжих	2016-2018	Банкууд	МБ	ХХ	Иргэд санхүүгийн зөв зуршилд суралцаж, үндэсний хуримтлал нэмэгдсэн байна.
		3	Иргэд гэр бүлээрээ болон хувиараа бизнес эрхлэхийг санхүүгийн болон зах зээлтэй холбох бодлогоор дэмжих	2016-2030	ХЯ	СЯ, МУХАУТ	ОУБ, ХЭДС	Жилд дунджаар 8 мянгаас доошгүй хүнийг хувиараа болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр бизнес эрхлэхийг дэмжих замаар ажлын байрыг шинээр бий болгох буюу тогтвортой хадгалсан байна.
		4	Малчид, хөдөөгийн ядуу өрхийн ногоон үйлдвэрлэл эрхлэх ур чадварыг дээшлүүлж, хөнгөлөлттэй зээл, тоног төхөөрөмжөөр дэмжих	2016-2020	ХХААЯ	ХЯ, БОНХАЖЯ	МХС, ОУБ	Жилд дунджаар 100-гаас доошгүй малчин өрхөд хөнгөлөлттэй зээлийн үйлчилгээ үзүүлж, тоног төхөөрөмж олгох ажлын хүрээнд ногоон үйлдвэрлэл эрхлэх ур чадварыг дээшлүүлсэн байна.
		5	Ахмад настныг насан туршийн боловсрол эзэмших, чадавхдаа нийцсэн хөдөлмөр эрхэлж, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох	2016-2018	ХЯ	ХАХНХЯ, ХЯ, БСШУЯ		Ахмад настны нийгмийн хамгааллын тухай болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулиудын холбогдох зохицуулалтыг боловсронгуй болгосон байна. Ахмад настнууд хөдөлмөр эрхэлж, нийгэмд идэвхтэй оролцох боломж нэмэгдэнэ.
		6	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, бага насны хүүхэдтэй эмэгтэйчүүд, ахмад настны амьжиргаанд хүрэлцэхүйц тэтгэвэр, тэтгэмж олгох, эмзэг бүлгийн иргэдэд хүнсний бүтээгдэхүүн олгох зохицуулалтыг сайжруулах	2016-2020	ХАХНХЯ		УТ	Тэтгэвэр тэтгэмж болон хүнсний бүтээгдэхүүн олгох халамжийн хууль, эрх зүйн зохицуулалтыг сайжруулсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, бага насны хүүхэдтэй эмэгтэйчүүд, ахмад настны амьжиргаа дээшилнэ.
4.4	Иргэдийг мэргэжлийн боловсролын сургалтад хамруулж, хөдөлмөрийн зах зээлд зуучлах, хүүхэд асрах эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлж, амьдрал ахуйд хүрэлцэхүйц цалин олгох	1	Мэргэжлийн боловсрол олгох сургалтыг олон улсын жишигт хүргэх, бүс нутгийн онцлог, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлж төрөлжүүлэн хөгжүүлэх	2016-2025	ХЯ	БСШУЯ	УТ, ОУБ	Орон нутгийн үйлдвэржилтийн бааз, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг харгалзан МСҮТ-ийг төрөлжүүлэн хөгжүүлж, мэргэжилтэй ажиллах хүчин бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгоно.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга зам	№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт
		2	Залуусыг хөдөлмөрийн зах зээлд бэлтгэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	2016-2025	ХЯ		ХЭДС, ОУБ	Их, дээд сургууль, МСҮТ төгсөгчдөд зөвлөгөө, мэдээлэл өгөх, бүтээн байгуулалт, орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулахад нь дэмжлэг үзүүлж, хөдөлмөрийн зах зээлд бэлтгэх хөтөлбөрт жилд 5 мянгаас доошгүй залуусыг хамруулсан байна.
		3	Бага насны хүүхдээ асрах эцэг, эхийн хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх, хүүхэд харах үйлчилгээний чанарт тавих хяналт, санхүүжилтийн тогтвортой байдлыг хангах	2016-2020	ХЯ	ХАХНХЯ, АНЗД	УТ, ОУБ	Бага насны хүүхэд эрүүл аюулгүй, хамгаалагдсан орчинд амьдрах, сурч хүмүүжих эрх хангагдана.
		4	Бага, дунд орлоготой иргэдийн орлогыг хамгаалах үүднээс цалингийн хэмжээнээс хамааралтай нийгмийн даатгалын шимтгэлийн уян хатан зохицуулалтыг бий болгох	2016-2017	ХАХНХЯ	ХЯ, НДЕГ	УТ	Нийгмийн даатгалын шинэчлэлийн хүрээнд шимтгэлийн уян хатан зохицуулалт бий болж бага дунд орлоготой иргэдийн орлогын баталгаа хангагдана.
4.5.	Хүн амын хүнсний хангамж, хүртээмжийг сайжруулж аюулгүй байдлыг хангах, эрүүл аж төрөхөд шаардлагатай нийгмийн үйлчилгээг бүх нийтэд тэгш хүртээх боломжийг бүрдүүлэх	1	Хүнсний сүлжээнд ногоон хөгжлийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх, эрүүл, аюулгүй, тэжээллэг хүнсээр хүн, амыг жигд хүртээмжтэй хангах, импорт орлох хүнсний үйлдвэрлэлийг дэмжих үйл ажиллагааг эрчимжүүлэх	2016-2030	ХХААЯ	БОНХАЖЯ, АҮЯ, ХХ	УТ, ХХ	Дотоодын үйлдвэрлэлээр хүн амын хүнсний хэрэгцээ, аюулгүй байдлыг хангах, импортын хүнсний эзлэх хувийг жил бүр 5-аас доошгүй хувиар бууруулна.
		2	Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд "Үйлдвэрлэлийн зохистой дадал", "Эрүүл ахуйн зохистой дадал", "Хөдөө аж ахуйн зохистой дадал", "Аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоо" нэвтрүүлэн, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний сав, баглаа, боодол болон хадгалах, тээвэрлэх стандартыг боловсруулж мөрдүүлэх	2016-2020	ХХААЯ	СТХГ, ЗТЯ	УТ	Хүнсний аюулгүй байдлыг хангах, эрсдэлийг бууруулахад чиглэсэн тогтолцоо бүрдсэн байна.
		3	Хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэл, чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог төлөвшүүлэх, эко ложистик сүлжээг хөгжүүлэх	2016-2020	ХХААЯ	АҮЯ, бүх шатны Засаг дарга	УТ, ОНТ, ХХ	Хүн амыг аюулгүй, чанартай хүнсээр хүртээмжтэй хангахад чиглэсэн үйл ажиллагаа хэрэгжинэ. Хүнсний бүтээгдэхүүний эко ложистикийн сүлжээг бүх аймаг, нийслэлд бий болгоно.
		4	Органик хүнсний эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлж, газар зүйн заалттай брэнд бий болгох, импортыг орлох хүнсний бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх	2016-2030	ХХААЯ	БОНХАЖЯ, ХХ	УТ, ОНТ, ХХ	Органик хүнсний хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт батлагдаж, газар зүйн заалттай бүтээгдэхүүний нэр, төрөл нэмэгдсэн байна. Импортын хүнсний эзлэх хувийг жил бүр 5-аас доошгүй хувиар бууруулна.
		5	Баяжуулсан хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрийг дэмжиж, биологийн идэвхт хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, генетикийн өөрчлөлттэй хүнсний бүтээгдэхүүний хяналтыг сайжруулах	2016-2030	ХХААЯ	ЭМСЯ, МХЕГ, БОНХАЖЯ, СЯ, АНЗД	УТ	Баяжуулсан хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэж, хүнс, хүнсний түүхий эдийн хяналт сайжирна.
		6	Нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх орчин, нөхцөлийг иргэн бүрт хүртээмжтэй хэлбэрээр бий болгох	2016-2020	БСШУЯ	ЭМСЯ, АНЗД	УТ	Иргэд нийтийн биеийн тамираар хичээллэх орчныг бүрдүүлсэн байна.


№	Зорилтыг хэрэгжүүлэх арга зам	№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт
4.6.	Байгалийн хүчин зүйл, баялгаас шууд хамаарал бүхий иргэдийн амьжиргааг сайжруулах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг даван туулах чадавхийг бэхжүүлэх	1	Сендайн үйл ажиллагааны хүрээний зарчим, тэргүүлэх чиглэлд нийцүүлэн хэрэгжилтийг хангах гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний стратеги, төлөвлөгөөг шинэчлэн тодотгож хэрэгжүүлэх	2016-2030	ОБЕГ	Яамд	УТ, ОНТ	Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, гамшгийн эрсдэлийг бууруулж, бэлэн байдлыг хангах, даван туулах чадавхыг бэхжүүлсэн байна.
		2	Хөдөө орон нутагт уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, байгалийн гамшгийн эрсдэлийг даван туулах чадавхийг бэхжүүлж, амьжиргааг сайжруулахад чиглэсэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2016-2025	БОНХАЖЯ	ХХААЯ	ОУБ	Иргэдийн орлого нэмэгдэж, амьжиргаа сайжирна.
		3	ТХГН-ийн орчны бүсэд малчдын аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэх, аж ахуй эрхлэх чадавхийг дээшлүүлж, ЖДҮ эрхлэгч болгон хөгжүүлэх	2016-2022	БОНХАЖЯ	АҮЯ	ОУБ, УТ	Орчны бүсийн дэд хөтөлбөр батлагдсан байна. Малчин өрхийн жуулчдад үйлчилгээ үзүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулах, орлогоо нэмэгдүүлэхэд чиглэсэн төсөл хэрэгжүүлсэн байна.
		4	Цаг агаарын онцгой нөхцөл, байгалийн гамшгийг хохирол багатай даван туулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор мал аж ахуй, газар тариаланг даатгалын тогтолцоонд бүрэн хамруулах зохицуулалт хийх	2016-2017	ХХААЯ		УТ	Цаг агаарын аюулт үзэгдэл, байгалийн гамшгийг хохирол багатай даван туулах, иргэдийн амьжиргаа эрсдэлд орохгүй байх баталгаа нэмэгдэнэ.
		5	Байгалийн гамшгийн улмаас малгүй болсон иргэдийг хөнгөлөлттэй зээл, тусламжаар дахин малжуулах, эдийн засгийн бусад салбарт шилжиж ажиллахад шаардлагатай мэргэжил, ур чадвар эзэмшүүлж, ажлын байраар хангах	2016-2018	ХХААЯ	ХЯ	ХЭДС	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн агуулгыг боловсронгуй болгож, хамрах хүрээг өргөжүүлэх замаар жилд 100-гаас доошгүй малчин өрхийн орлогын тогтвортой байдлыг хангасан байна. Хөдөлмөр эрхлэлтийн сургалтаар дамжуулж малчдын эдийн засгийн бусад салбарт ажиллахад шаардлагатай ур чадварыг эзэмшүүлнэ.
		6	Ой, бусад дагалт баялгийг ашиглах боломжит нөөцийн хүрээнд байгальд халгүй аргаар бэлтгэж, эко цэвэр, үндэсний "брэнд бүтээгдэхүүн" үйлдвэрлэгч ЖДҮ-ийг чадавхжуулах, хөнгөлөлттэй зээл, санхүүгийн түрээсийн үйлчилгээгээр дэмжих	2017-2020	АҮЯ	БОНХАЖЯ, ХЯ	ОУБ, ЖДҮДС	Ой, байгалийн баялгаар "брэнд бүтээгдэхүүн" үйлдвэрлэгч ЖДҮ эрхлэгчийг чадавхжуулж, хөнгөлөлттэй зээл, санхүүгийн түрээсийн үйлчилгээгээр дэмжих зохицуулалтыг бий болгож, санхүүжилтийг нэмэгдүүлнэ.
		7	Байгалийн нөөцийн хамтын менежментийг дэмжиж, ойн цэвэрлэгээ, цөлжилтөөс сэргийлэх, нөхөн сэргээх үйл ажиллагаанд орон нутгийн иргэдийг эхний ээлжинд татан оролцуулах	2016-2020	ХЯ	БОНХАЖЯ	ХЭДС, БХС, УТ	Байгаль орчныг хамгаалах, бохирдлыг бууруулах, нөхөн сэргээх, эрүүл аюулгүй эко орчныг бүрдүүлэхэд чиглэсэн хөтөлбөрт жилд дунджаар 15 мянгаас доошгүй хүнийг хамруулсан байна.



№	Зорилтыг хэрэгжүүлэх арга зам	№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт
4.7.	Алслагдсан нутагт бэлчээрийн даацад тохируулан мал аж ахуй эрхэлж, усны эх, булаг, шандыг арчилж тордох зэргээр бэлчээрийн доройтлоос сэргийлэх чиглэлээр санаачилгатай ажиллаж байгаа малчдад экосистемийн үйлчилгээний төлбөрийн урамшуулал олгох механизмыг бүрдүүлэх	1	Экосистемийн үйлчилгээний төлбөрийн тогтолцоогоор дамжуулан алслагдсан нутагт бэлчээрийн доройтлоос сэргийлэх, цас борооны ус тогтоож хөв, цөөрөм байгуулж бэлчээрийн усан хангамжийг сайжруулах чиглэлээр санаачилгатай ажиллаж байгаа малчдыг урамшуулж дэмжих	2017-2030	ХХААЯ	БОНХАЖЯ, бүх шатны Засаг дарга	УТ, ОНТ,	Экосистемийн үйлчилгээний төлбөрийн тогтолцоо төлөвшиж, төлбөрөөс олсон орлогыг малын тоо толгой, сүргийн зохистой бүтцээ нутгийн онцлогт тохируулан хадгалж, отор нүүдэл хийж бэлчээр сэлгэн хамгаалдаг малчдад олгодог систем бүрдэнэ. УБ хотоос 600 км-ээс дээш зайд алслагдсан аймаг, сумын малчдад урамшуулал олгодог систем бүрдэнэ.
		2	Бэлчээрийн газрын үнэ цэнийг тогтоох, газар ашиглалт, мал аж ахуйн салбараас ялгарах хүлэмжийн хийн тооллого явуулах арга зүйг туршин нэвтрүүлж тооцоолох	2016-2020	БОНХАЖЯ	ХХААЯ, ОУБ	ОУБ	Байгалийн эдийн засгийн үнэ цэнэ, үр өгөөжийг тогтоох систем бүрдэж, мал аж ахуй эрхлэлтээс үүсэх байгальд учруулах нөлөөллийн талаарх судалгаа тоон мэдээлэл бүрдэнэ.

## STRATEGIC OBJECTIVE #5

ENCOURAGE EDUCATION, SCIENCE, AND  
TECHNOLOGY TO SERVE AS THE  
CATALYST FOR GREEN DEVELOPMENT,  
AND DEVELOP CULTURAL VALUES AND  
LIVELIHOODS THAT ARE IN HARMONY  
WITH NATURE.



№	Зорилтыг хэрэгжүүлэх арга зам	№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт
5.1	Тогтвортой хөгжлийн боловсролоор дамжуулан эх оронч үзэл, байгаль орчноо хамгаалах уламжлалт ёс заншил, байгальд ээлтэй амьдралын хэв маяг, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээний соёлыг төлөвшүүлэх	1	Тогтвортой хөгжил, байгаль орчны бүх нийтийн боловсролын өнөөгийн байдлыг үнэлж, тогтвортой хөгжлийн боловсролын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	2016-2030	БОНХАЖЯ	БСШУЯ	ОУБ	Хөтөлбөр хэрэгжүүлж, тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн үзэл санааг бүх нийтэд хүргэж, хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээний соёлыг дэлгэрүүлнэ.
		2	Тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн үзэл санааг бүх шатны сургалтын хөтөлбөрт тусгаж, байгаль хамгаалах уламжлалт ёс заншлаа өвлүүлэх, орчин үеийн амьдралын хэмнэлд нийцсэн хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээний соёлыг төлөвшүүлэх	2016-2030	БСШУЯ	БОНХАЖЯ	ОУБ	Бүх шатны сургалтын хөтөлбөрийн агуулга, сурах бичиг, үйл ажиллагаанд Тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн үзэл санаа тусгагдсан байна. Хүүхэд, багачуудад бага наснаас нь эхлэн байгальд ээлтэй, арвич хямгач сэтгэлгээг суулгана.
		3	Тогтвортой хөгжлийн үзэл санаа, ногоон эдийн засгийн ойлголтыг их, дээд сургуулийн хөтөлбөрт тусгаж, сургалт-үйлдвэрлэлийг холбох гарааны компанийг бизнес инкубаторт бойжуулахад дэмжлэг үзүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх	2016-2020	БСШУЯ	БОНХАЖЯ	УТ, ОУБ	Их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт тогтвортой хөгжлийн үзэл санаа тусч, судлаач, оюутнууд инновацийг бүтээгч хүчин болж төлөвшинэ.
		4	Эко сургуулийн үйл ажиллагааг дэмжиж байгаль орчноо хамгаалах уламжлалт ёс заншил, байгальд ээлтэй амьдралын хэв маягийг хүүхэд, залууст төлөвшүүлэх	2016-2022	БОНХАЖЯ	БСШУЯ	ОУБ	Эко сургуулиар дамжуулан уламжлалт ёс заншил, байгаль хамгаалах орчин үеийн арга технологи, байгальд ээлтэй амьдралын хэв маяг, зөв хандлагыг түгээнэ.
		5	Тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн үзэл санааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах стратеги төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	2016-2020	БОНХАЖЯ		ОУБ	Тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн талаарх мэдлэгийг олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар хүргэнэ.
		6	Ногоон хөгжил, ногоон эдийн засгийн мэдлэг олгох зорилтот бүлгүүд рүү чиглэсэн гарын авлага боловсруулах, сургалтын онлайн системийг хөгжүүлэх	2016-2020	БОНХАЖЯ		ОУБ	Сургалтын модуль, гарын авлага гарсан байна.
		7	Төв, орон нутгийн удирдлага, аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтэд ногоон хөгжил, ногоон эдийн засгийн талаар сургалт, семинар зохион байгуулах	2016-2020	БОНХАЖЯ	МҮХАУТ	ОУБ	Ногоон хөгжил, ногоон эдийн засгийн талаарх мэдлэгийг түгээн дэлгэрүүлнэ.
5.2	Байгаль орчны удирдлагын MNS ISO14000 багц стандартыг аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрүүлэхийг хөхиүлэн дэмжиж, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээний хэмнэлттэй зөв дадлыг бий болгох	1	Байгаль орчны удирдлагын багц стандартыг нэвтрүүлэхэд чиглэсэн холбогдох судалгаа хийж, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлж дэмжих	2016-2020	БОНХАЖЯ	АҮЯ, бусад яамд, СХЗГ	ОУБ	Судалгаа хийгдэж, стандарт нэвтрүүлэхийг хөхиүлэн дэмжих, бизнесийн салбаруудыг ногоон болгох стратеги төлөвлөлт боловсруулж хэрэгжүүлнэ.
		2	Байгаль орчны удирдлагын ISO 14001 стандартыг сурталчлан таниулах болон нэвтрүүлэх, үнэлэх, хянан баталгаажуулах үндэсний чадавхийг бүрдүүлж дадлажуулах ажлыг зохион байгуулах	2016-2030	БОНХАЖЯ	СХЗГ, МҮХАУТ	ОУБ, ХХ	Сургалт, сурталчилгааны хөтөлбөр, сургалтын модуль боловсруулж, мэргэжилтэн сургана.
		3	Байгаль орчны удирдлагын MNS ISO 14001, 14051 стандартыг аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлж сурталчлах тогтолцоог нэвтрүүлэх	2017-2025	БОНХАЖЯ	СХЗГ	УТ	Нийгмийн хариуцлагаа ухамсарлан MNS ISO14001 стандартыг нэвтрүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага нэмэгдсэн байна.

5.3	Уул уурхайн болон хөгжлийн томоохон төслийг хэрэгжүүлэхийн өмнө байгаль, түүх, соёлын өвд учруулах эрсдэлийн үнэлгээ хийж, хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх	1	Уул уурхайн болон бүс нутгийн хөгжлийн томоохон төслийг хэрэгжүүлэхийн өмнө байгаль, түүх, соёлын өвийн цогц үнэлгээг хийх чиглэлээр эрх зүйн орчныг сайжруулах	2016-2018	БСШУЯ, БОНХАЖЯ		УТ	Урьдчилсан судалгаа хийж, хэрэгцээ, шаардлагыг тогтоон холбогдох зохицуулалтыг бүрдүүлнэ.
5.4	Ногоон хөгжлийг дэмжсэн цэвэр технологи, инновацийг хөгжүүлж, шинжлэх ухаан технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийг 2020 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувь, 2030 онд 3 хувьд хүргэн, ногоон хөгжлийн хурдасгуур болгох	1	Олон улсын байгууллагууд болон сангуудаас санхүүжилт татах төсөл боловсруулах чадавх бүрдүүлэх, ногоон хөгжлийг дэмжсэн инноваци, цэвэр технологийн судалгаа хөгжлийг санхүүжүүлэх эх үүсвэрийг нэмэгдүүлэх	2016-2030	БСШУЯ	СЯ, бусад яамд	ОУБ, УТ, ХХ	Ногоон хөгжилд чиглэсэн судалгаа, туршилтын ажлын санхүүжилтийн эх үүсвэр, шинжлэх ухаан, технологийн төслийн тоо нэмэгдсэн байна.
		2	Шинэ техник, технологийг өөрийн орны нөхцөлд үр дүнтэй ашиглах, тэргүүлэгч техник, технологитой харилцах хүний нөөцийг системтэйгээр бэлтгэх	2016-2025	БСШУЯ	ЭШБ, ХХ	УТ, ХХ	Шинэ техник, технологийг ойлгож, хурдтай шилжүүлж чаддаг чадварлаг хүний нөөцтэй болно.
		3	Залуу эрдэмтэн судлаачдын дунд ногоон хөгжил, ногоон технологийн чиглэлээр төсөл шалгаруулж санхүүжүүлэх	2016-2020	БОНХАЖЯ	СЯ, БСШУЯ	ОУБ	Залуу судлаачдад грант олгож, гэрээ байгуулсан байна.
5.5	Инноваци, биотехнологи, нанотехнологи дамжуулах, бойжуулах, нутагшуулж үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд шинжлэх ухааны байгууллага, аж үйлдвэрийн хамтын ажиллагааг өргөжүүлэн, чанар, онцлогоороо тэргүүлсэн ногоон бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	1	Төр, хувийн хэвшил, судалгаа шинжилгээний байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлж, эдгээрийн гурвалсан холбоонд суурилсан дэвшилтэт техник, өндөр технологи бойжуулах, нутагшуулах үйлдвэрлэлийг татвар, зээл, худалдан авалтын бодлогоор дэмжих	2016-2025	АҮЯ	БСШУЯ, Яамд, МҮХАҮТ, ЭШБ	УТ, ХХ	Судалгаа, технологид суурилсан чанар, онцлогоороо тэргүүлсэн үндэсний ногоон бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэнэ.
		2	Эрдэм шинжилгээний байгууллагын дэргэд ногоон бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гарааны компани байгуулж, үр бүтээлтэй ажиллахыг дэмжих	2016-2025	БСШУЯ	АҮЯ	УТ, ХХ	Гарааны компаниуд байгуулагдаж, тогтвортой ажиллаж эхэлсэн байна.
		3	Инновацийн бодлого, салбаруудын инновацийг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг салбарын бодлого, хөтөлбөртэй уялдуулан боловсруулж хэрэгжүүлэх	2016-2025	БСШУЯ	Яамд	УТ	Инновацийн бодлого батлагдаж, дэд хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг хангана.

## STRATEGIC OBJECTIVE #6

DEVELOP AND IMPLEMENT A  
POPULATION SETTLEMENT PLAN IN  
ACCORDANCE WITH CLIMATE CHANGE,  
WHILE CONSIDERING THE  
AVAILABILITY OF NATURAL RESOURCES  
AND THE RESILIENCE OF REGIONS.



№	Зорилтыг хэрэгжүүлэх арга зам	№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт
6.1	Уур амьсгалын өөрчлөлтийн хэтийн хандлага, байгалийн нөөц даацад нийцүүлж, хүн амын хэт төвлөрөл үүсэхээс сэргийлсэн, өөрийгөө тэтгэх чадвартай “ногоон”, “ухаалаг” жижиг хот, тосгоныг хөгжүүлж, орон нутагт тав тухтай ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх	1	Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг боловсруулж батлуулан, хэрэгжилтийг үе шаттайгаар зохион байгуулах	2017-2030	БХБЯ	СЯ, Яамд, АНЗД	УТ	Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн талаарх бодлого тодорхойлогдож хэрэгжиж эхэлнэ.
		2	Хот, суурины эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу аймгийн төвүүд болон 15000-аас дээш хүн амтай суурин газрыг улсын зэрэглэлтэй хот болгох асуудлыг боловсруулж шийдвэрлүүлэх	2016-2018	БХБЯ	ЗГХЭГ, АНЗД, Яамд		Хүн амын хэт төвлөрлийг сааруулах, шилжилт хөдөлгөөнийг багасгах, иргэд орон нутагтаа тогтвортой суурьшин амьдарч, ажил, хөдөлмөр эрхлэх, хотуудын нийгэм, эдийн засгийн хөгжлийг түргэтгэх нөхцөлийг бүрдүүлнэ.
		3	“Ногоон”, “Ухаалаг” хот, суурины шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, үнэлгээний систем бий болгох	2016-2018	БХБЯ	БОНХАЖЯ, АНЗД	ОУБ	Шалгуур үзүүлэлт, үнэлгээ, урамшууллын системтэй болсон байна.
		4	Хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийж, “Ногоон”, “Ухаалаг” хөгжлийн зарчмыг тусган шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх	2016-2030	БХБЯ	АНЗД	ОНТ, ОУБ, ХХ	“Ногоон”, “Ухаалаг” хотын зарчимд нийцсэн хөгжлийн төлөвлөлт хийгдэж хэрэгжинэ.
		5	Хархорин хотыг байгаль орчинд ээлтэй хот болгон хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	2017-2030	БХБЯ	АЗД	УТ	Жишиг “Ногоон” хот бий болно.
		6	Хөшигийн хөндийд баригдах олон улсын нисэх буудлыг даган бий болох “Ухаалаг” жишиг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	2016-2030	БХБЯ	ЗТЯ, АНЗД	УТ	Жишиг “Ухаалаг” хот бий болно.
		7	Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлагын дагуу дагуул, хаяа хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг “Ногоон” хотын зарчимд нийцүүлэн боловсруулж хэрэгжүүлэх	2016-2030	НЗД	БХБЯ, бусад яамд	УТ, ОНТ	Иргэд тав тухтай ажиллаж, амьдрах орчин, нөхцөл бүрдсэн жишиг дагуул хот, дүүрэгтэй болно.
		8	Уул уурхайн үйлдвэрлэлийг түшиглэсэн хот суурины орчны газрыг уурхайн хаалтын хүрээнд нөхөн сэргээж, байгаль орчинд ээлтэй жишиг “Ногоон” хот болгон хөгжүүлэх	2016-2020	БХБЯ	УУЯ, БОНХАЖЯ, АНЗД, ХХ	ХХ, УТ	Уул уурхайн хаалтын дараах аялал жуулчлал зэрэг тодорхой үйл ажиллагааг түшиглэсэн жишиг “Ногоон” хотыг бий болгоно.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга зам	№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт
6.2	Хот, тосгоны газар ашиглалт, барилгажилтын бүсчлэл, дэд бүтцийн төлөвлөлтийг боловсронгуй болгон хэрэгжүүлэх, хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг бий болгож агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах	1	Хот байгуулалт, газрын харилцааны хууль тогтоомж, хот, суурины нутаг дэвсгэрийн бүсчлэлийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох	2016-2018	БХБЯ	БОНХАЖЯ	УТ	Хот, суурины төлөвлөлт, газар ашиглалт, барилгажилтын бүсчлэл, төлөвлөлтийн хариуцлагын эрх зүйн зохицуулалт бүрдэж мөрдөгдөнө.
		2	Улаанбаатар хотын ус хангамж, ариутгах татуургын мастер төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	2016-2025	НЗД	БХБЯ, БОНХАЖЯ	ОНТ, ХХ	Хотын ус хангамж, сайжруулсан ариун цэврийн байгууламжийн хүртээмж нэмэгдэж, орчны бохирдол буурна.
		3	Агаар, хөрс, усыг бохирдуулж байгаа эх үүсвэр, хаягдлын тооллого явуулж, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлж, хяналт-шинжилгээг үр дүнтэй болгох	2016-2020	БОНХАЖЯ	АНЗД	УТ, ОНТ	Бохирдуулагч нь төлбөр төлөх механизмыг хэрэгжүүлэх үндэс бүрдэж, орчны бохирдол багасна.
		4	Улаанбаатар хотын гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг боловсронгуй болгох жишиг төсөл хэрэгжүүлж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх	2016-2019	БОНХАЖЯ	АНЗД	ОУБ, ХХ	Манай орны нөхцөлд тохирсон өрхийн ариун цэврийн байгууламжийн шийдлийг олж, туршин нэвтрүүлсэн байна. Эхний ээлжинд 8000 өрх хамрагдана.
		5	Бохирдсон хөрс, голын хурдсыг цэвэрлэх үйл ажиллагааг шат дараатайгаар зохион байгуулж, нөхөн сэргээж, ногоон байгууламж бий болгох	2016-2020	АНЗД	БОНХАЖЯ	УТ, ОУБ	Хөрс, усны бохирдлын голомтот эх үүсвэрийг арилгана.
6.3	Улаанбаатар хот болон бусад хот, сууриныг дахин төлөвлөж, эдэлбэр газарт ногоон байгууламжийн эзлэх хувь хэмжээг 2020 он гэхэд 15 хувь, 2030 он гэхэд 30 хувьд хүргэх	1	Хот, суурины ногоон байгууламжийн эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх	2016 -2017	БХБЯ	БОНХАЖЯ		Хот, суурины ногоон байгууламжийг төлөвлөх, байгуулах, ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх эрх зүйн орчин бүрдэнэ.
		2	Улаанбаатар хотын ногоон байгууламжийн мастер төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх	2016-2020	НЗД	БХБЯ, АЗД	ОНТ	Цэцэрлэгжүүлэлт батлагдсан тодорхой төлөвлөгөө, графикийн дагуу хийгдэнэ. УБ хотод 2100 га талбай бүхий томоохон цэцэрлэгүүд байгуулагдаж, 150-иас доошгүй га талбайг цэцэрлэгжүүлнэ.
		3	Нэг болон олон наст цэцэг, мод сөөг үржүүлгийн газруудыг байгуулж, тарьц суулгацаар дотоодын хэрэгцээг хангах	2016-2030	АНЗД		ОНТ, ХХ	Ногоон ажлын байр нэмэгдэж, мод сөөг, цэцгийн тарьц, суулгацаар бүрэн хангана.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга зам	№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт
6.4	Үр ашигтай, хэмнэлттэй технологийг дэмжих, хүн амд амьдрах орчны эрүүл ахуйн мэдлэг, зөв дадлыг олгох замаар хаягдлыг бууруулах зохистой менежментийг төлөвшүүлж, хог хаягдлыг боловсруулж дахин ашиглах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, байгальд булж зайлуулах хаягдлын хэмжээг 2020 онд 20%, 2030 онд 40% бууруулах	1	Бодит салбарууд, орон нутгийн засаг захиргаад хог хаягдлын менежментийг сайжруулах мастер төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	2016-2030	Бүх яамд	АНЗД	УТ, ХХ	Аймаг, нийслэл хог хаягдлын зохистой менежмент явуулж, эрүүл цэвэр орчин бүрдэнэ.
		2	Хог хаягдлыг бууруулах, ангилан ялгах талаар иргэдийн мэдлэг, ухамсрыг дээшлүүлэх, дадал суулгах сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх	2016-2030	БОНХАЖЯ	АНЗД	О У Б , ОНТ	Иргэдийн мэдлэг, ухамсар дээшилснээр ил задгай хогны хэмжээ багасч, эрүүл, цэвэр орчин бүрдэнэ.
		3	Хог хаягдлын талаарх цогц ойлголт олгох сургалтыг сургуулийн өмнөх насны болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт оруулж, зөв дадлыг төлөвшүүлэх	2016-2030	БСШУЯ	БОНХАЖЯ, АНЗД	УТ	Хүүхдэд бага наснаас нь зөв дадал олгосноор иргэдийн сэтгэхүйд өөрчлөлт оруулна.
		4	Эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хатуу хог хаягдлын цэг талбай байгуулах	2016-2020	АНЗД		ОНТ	Хот, суурин бүрт эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хатуу хог хаягдлын цэгтэй болсон байна.
		5	Аюултай хог хаягдлын менежментийг сайжруулах мастер төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	2017-2025	БОНХАЖЯ	АНЗД	УТ, ХХ	Менежмент сайжирч, аюултай хог хаягдлын эрсдэлийг бууруулна.
		6	Хог хаягдлыг дахин боловсруулах, эрчим хүч үйлдвэрлэх эко цогцолбор байгуулах замаар эдийн засгийн эргэлтэд оруулж, хөрсөөр булж зайлуулах замаар хог хаягдлыг бууруулах (Наран, Цагаан давааны төвлөрсөн хогийн цэгийн газрыг түшиглэх)	2016-2030	НЗД	БОНХАЖЯ	ХХ, УТ	2020 он хүртэл 2, 2030 он хүртэл 3 үйлдвэр байгуулж, хогны хэмжээг бууруулна.
		7	Ашиглалтаас хасагдсан авто тээврийн хэрэгслийг задалж, түүхий эд болгон ашиглах, устгах төсөл хэрэгжүүлэх	2016-2020	ЗТЯ	НЗД	УТ, ОУБ	Ашиглалтаас хасагдсан тээврийн хэрэгслийн эд ангийг дахин боловсруулах үйлдвэртэй болсон байна.



№	Зорилтыг хэрэгжүүлэх арга зам	№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт
6.5	Байгаль орчинд ээлтэй, хүртээмжтэй, найдвартай, эрсдэлгүй нийтийн тээврийн төрөл, үйлчилгээг хөгжүүлж, иргэд ая тухтай зорчих орчныг бүрдүүлэх	1	Нийслэлийн нийтийн тээвэрт “Тусгай замын автобусны үйлчилгээ” (BRT)-г нэвтрүүлэх	2017-2019	ЗТЯ	БХБЯ, НЗД	УТ, ОУБ	64.5 км тусгай зам баригдаж, зорчигчдод шуурхай үйлчлүүлэх боломж бүрдэнэ.
		2	“Улаанбаатар метро” төсөл хэрэгжүүлэх	2017-2030	ЗТЯ	БХБЯ, НЗД	УТ, ОУБ	Амгалангаас Толгойт чиглэлд 8-9 минутын давтамжтай 10700 зорчигч үйлчлүүлэх боломж бүрдэнэ.
		3	Нийслэлийн нийтийн тээвэрт парк шинэчлэлт хийх, маршрут, зогсоолыг оновчтой, хүртээмжтэй төлөвлөж хэрэгжүүлэх	2016-2020	НЗД	ЗТЯ	ОНТ, ХХ	Стандартын шаардлага хангасан, хаягдал багатай, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зорчих боломжтой тээврийн хэрэгсэлтэй болно.
		4	Нийтийн тээврийн үйлчилгээнд байгаль орчинд халгүй тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх туршилт хийж хэрэгжүүлэх	2016-2025	ЗТЯ	НЗД	УТ	Нийтийн тээврийн үйлчилгээ байгаль орчинд халгүй байх туршилт, судалгаа хэрэгжүүлэх төлөвлөлт хийгдсэн байна.
		5	Хийн түлшийг нийтийн тээврийн үйлчилгээнд нэвтрүүлэх туршилт явуулах, шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгаа хийх	2016-2020	ЗТЯ	УУЯ, ЭХЯ	УТ, ОУБ	Туршилт судалгаа хийгдсэн байна.
		6	Дотоодод угсарч байгаа монбус, доубус болон хийн түлшний нэмэлт төхөөрөмж суурилуулсан тээврийн хэрэгслийн техникийн болон хөдөлгөөний аюулгүй байдлын үзүүлэлтийг шалгах тестийн төвийн ТЭЗҮ боловсруулж хэрэгжүүлэх	2016-2020	ЗТЯ	НЗД	УТ, ОНТ	Техникийн тестийн төв байгуулагдаж, зорчигчдын аюулгүй байдал хангагдсан байна.
		7	Хот хоорондын авто замын дагууд зорчигчийн ая тухыг хангасан, ногоон шийдэлтэй үйлчилгээний цогцолбор бүхий түр буудаллах зогсоолын нэг маягийн зураг төсөл боловсруулах, нутгийн иргэдийн оролцоотойгоор төлөвлөж байгуулах	2016-2020	ЗТЯ	БОНХАЖЯ, Бүх шатны ЗД	ОНТ, ХХ	Зорчигчийн ая тухыг хангасан авто зогсоолтой болох, орон нутгийн иргэд байнгын ажлын байртай болно.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга зам	№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт
6.6	Явган хүн зорчих хэсэг, ногоон байгууламж, дугуйн зам, зогсоолын төлөвлөлт, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, иргэд явган явах, дугуйгаар зорчих орон зайг нэмэгдүүлэх	1	Хот, тосгоны төлөвлөлт ба барилгажилтын норм ба дүрмийг ногоон хотын төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн шинэчлэн боловсруулах	2016-2020	БХБЯ	БОНХАЖЯ, НЗД	БННС	Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм шинэчлэн боловсруулагдсан байна.
		2	Авто зогсоолын төлөвлөлт, байгуулалт, ашиглалт, хяналтын харилцааг зохицуулах эрх зүйн орчин бүрдүүлэх	2016-2017	БХБЯ	ЗТЯ		Эрх зүйн орчин бүрдэж, хот төлөвлөлт зохистой болно.
		3	Явган хүн зорчих хэсэг, дугуйн зам, ногоон байгууламж, зогсоолын төлөвлөлтийн байршлыг хот, суурины ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан тогтоож, зураг төслийг боловсруулж хэрэгжүүлэх	2016-2030	АНЗД	БХБЯ, ЗТЯ	ОНТ	Иргэд явган явах, дугуйгаар зорчих боломжоор хангагдана.
		4	Туул, Сэлбэ голын эргийн дагууд сэргээн сайжруулах төсөл хэрэгжүүлж иргэд амарч зугаалах, спортоор хичээллэх ая тухтай орчин бүрдүүлэх	2016-2020	НЗД	БОНХАЖЯ	ОУБ, ОНТ	Баянзүрхийн гүүрнээс Сонсголонгийн гүүр хүртэл 21 км урт дугуйн зам, бусад байгууламжтай болно.



## Education for Sustainable Development project address:

Midtown office, 4th floor  
Peace Avenue 15/2, Olympic Street  
Sukhbaatar District, Ulaanbaatar  
Mongolia



+976 75770989



[avid.enkhjargal@giz.de](mailto:avid.enkhjargal@giz.de)

